ОРХОН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| № | ТЕЗ-ийн үр дүн | Хөтөлбөрийн үр дүн | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Төсөв /сая.төг/ | Хөрөнгийн эх үүсвэр | Хүрсэн түвшин | Зарцуулсан төсөв /сая.төг/ | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Он | Түвшин | | | | | | | |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 1: ЭХ ХЭЛ, ТҮҮХ СОЁЛЫГ ДЭЭДЭЛСЭН, ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ БИЙ БОЛГОНО** | | | | | | | | | | | | | | |
| 1. | 1.1.Соёлын биет болон биет бус өвийг сурталчилж түгээн дэлгэрүүлнэ. | 1.1.1.Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн хотын соёлыг тээгч иргэнийг төлөвшүүлнэ. | 1.1.1.1.Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлж иргэд олон нийтийн хяналт оролцоог сайжруулах | Түүх, соёлын дурсгалыг гэрээгээр хамгаалж буй өрх, иргэдэд зориулсан арга хэмжээ | Тоо | 2023 | 1 | 1 | 8.0 | ОНТ | 1 | 10.0 | 100 | Аймгийн нутаг дэвсгэрт орших 28 газрын 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг хулгайн гэмт хэрэг зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн хяналт, оролцоог сайжруулах зорилгоор сумдын Засаг дарга нар, 20 малчин өрхтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалж буй өрхүүдийн урамшуулал болон дурсгалт газруудад мэргэжлийн байгууллагаас хяналт тавих зардалд 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. |
| 2. | | | 1.1.1.2. Монгол үндэсний соёлын онцлогийг агуулсан шинэлэг уран бүтээлийг Эрдэнэтийн иргэдийн хүртээл болгох | Иргэдийн хүртээл болгосон уран бүтээл | Тоо | 2023 | 1 | 1 | 30.0 | ОНТ | 3 | - | 100 | Тайлант хугацаанд Улсын Филармонийн Симфони оркестрын “Шилмэл бүтээл”-ийн 2 удаагийн тоглолтыг орон нутгийн иргэдийн хүртээл болгосон. Мөн Хүүхэд Залуучуудын Театрын "Шөнийн хун тайж", "Бүүвэй" хүүхдийн жүжиг, "Хатан сэнтийн хайлан" моно жүжиг, "Хөх төрийн бэрс" түүхэн жүжгүүдийг орон нутгийн иргэдэд үнэ төлбөргүй тоглож хүргэсэн. Үүнээс үндэсний соёлын онцлогийг агуулсан 3 уран бүтээлийг үзэгчдийн хүртээл болгосон байна. |
| 3. | | | 1.1.1.3. Айргийн гозгорын археологийн малтлагыг үргэлжлүүлэн хийж | Музейн үзмэрт буй олдвор | Тоо | 2024 | 48 | 49 | 50.0 | ОНТ | 50 | - | 100 | Монголын үндэсний Музейн малтлага судалгааны экспедицтэй аймгийн музей хамтран Айргийн гозгорын археологийн малтлагыг |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аймгийн Музейн үзмэрийн сан хөмрөгийг баяжуулах | | | | | | | | | | ажлыг 2 дурсгалд хийж 10 дэсийн 12 үзмэр олсон бөгөөд олдворуудад судалгааны ажил хийгдэж байна. 2024 онд айргийн гозгорт малтлага судалгааны ажлын үр дүнд 2 дэсийн 2 үзмэр Монголын соёлын өвийн үндэсний төвд сэргээн засвар, бэхжүүлэлт хийгдэн аймгийн музейн сан хөмрөгт бүртгэлжүүлсэн. |
| 4. | | | 1.1.1.4. Хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага, иргэдэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | Дэмжлэг авсан иргэд, байгууллага | Тоо | 2023 | 20 иргэн, 10 байгуулл ага | 25 иргэн, 10 байгууллаг а | 40.0 | ОНТ | 41 иргэн, байгуул лагад | 32.0 | 100 | Тайлант хугацаанд АНУ-д төгөлдөр хуурын уралдаанд Орхон аймгаас оролцсон сурагч Л.Сарангуад, АНУ-ын Бостон хотод зохион байгуулагдсан төгөлдөр хуурын олон улсын "А" зэрэглэлийн "Кришиндо" тэмцээнд Орхон аймгаас оролцсон 7 хүүхэд, 1 багшийн замын зардал, БНХАУ-д зохион байгуулагдсан “Цэнхэр гарагийн хүүхдүүд” олон улсын уралдаанд оролцох 21 хүүхдийн замын зардал, дуучин Д.Дагвадоржийн Польш улсад зохион байгуулагдсан “Great tenor tournament” уралдаанд оролцох зардалд, Дуу бүжгийн "Эрдэнэт" чуулгын уран бүтээлч С.Ариун-Эрдэнэ, Х.Мөнхбаяр, Н.Нямсүрэн нарын "Дэлхий аргадах ижий" уран бүтээлийн тоглолтын зардал, 4 дүгээр сургуулийн багш, хөгжмийн зохиолч Б.Дамбадаржаагийн уран бүтээлийн зардал, ахмад уран бүтээлч Н.Цэцэгсүрэнгийн “Өлгий нутгаа магтан дуулъя” аялан тоглолтын зардал, "Уран бийр" сургалтын төвийн багш Д.Цэгмидийн ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд явагдах гар зургийн уралдаан болон Улаанбаатар хотод зохион байгуулах уран зургийн үзэсгэлэнгийн зардал, "Дэнжийн цуурай" төрийн бус байгууллагаас Улаанбаатар хот болон Хөвсгөл |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | аймгийн уран бүтээлчидтэй хамтран зохион байгуулсан "Тэнгэрийн аялгуу" үндэсний хөгжмийн тоглолтын зардал, "Чөлөөлөх дайны ялалтад Монголчуудын оруулсан хувь нэмэр" марк, гэрэл зургийн үзэсгэлэнгийн зардал, Эрдэнэт хотоос төрөн гарсан "Outlaw" хамтлагийн 20 жилийн ойн тоглолтын зардал, "Төгөлдөр солонго" ТББ-аас зохион байгуулсан бүжгийн тэмцээн зэрэг нийт 41 иргэн, байгууллагад 32.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. |
| 5. | 1.2.Нийгмийн соён гэгээрлийг нэмэгдүүлнэ. | 1.2.1.Соёлын үнэт зүйлд тулгуурлан иргэдийн суурь хүмүүжлийг сайжруулах, соёлын үнэт зүйлийг хамгаална | 1.2.1.1.Бүх нийтийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ | Тоо | 2023 | 2 | 1 сургалт, 2 арга хэмжээ | 5.0 | ОНТ | 1 сургалт, 215 арга хэмжээ | 5.0 | 100 | Тайлант хугацаанд "Урин хавар-2025" яруу найргийн наадам, "Үндэсний бичиг үсэг, номын баяр-2025", "Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье", соёлын төвүүдээс хэрэгжүүлсэн кино боловсрол олгох арга хэмжээ, музейн боловсрол олгох хөтөлбөр, "Эх хэлний өдөр", "Үндэсний хувцасны өдөр", "Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай", хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зэрэг бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн 216 сургалт, арга хэмжээ, 3 аян зохион байгуулж, давхардсан тоогоор 77864 иргэнийг хамруулж, соёл урлагийн болон нөлөөллийн олон алт арга хэмжээг хэрэгжүүлэн 1,345.591 цахим хандалт авсан байна. |
| 6. | | | 1.2.1.2.Иргэдийн аж төрөх байдал "Хотын соёл-Хамтын соёл" хэм хэмжээг төлөвшүүлэх | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2023 | 1 | 2 | 50.0 | ОНТ | 2 | 40.0 | 100 | - Иргэд, хүүхэд залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлсэн, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа хандлага бүхий ухамсарт зан үйл, соёлд суралцуулах, иргэдийн амьдралд хотын соёл-хамтын соёлын хэм |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор "Соёлыг түгээе" аяныг 2025 онд “Соёлыг түгээе” аяныг “Зөв хандлага-хотын соёл” уриатайгаар 1 сарын хугацаанд зохион байгуулж соёлын салбарын 8 байгууллага соёл, нөлөөллийн 40 гаруй үйл ажиллагаагаар “Хотын соёл-Хамтын соёл”-ын хэм хэмжээний энгийн ойлголтын 21,000 гаруй иргэнд хүргэсэн байна. Уг аяны хүрээнд 33 төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байгууллага дээрээ тусгай төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу байгууллагын соёл, иргэдэд үзүүлэх үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар ажлуудыг зохион байгуулж, цахим орчинд олон нийтэд сурталчилж, Мал эмнэлгийн газар, Биеийн тамир спортын газар, Нийгмийн даатгалын газар, Бүсийн оношилгоо эмчилгээ төв зэрэг байгууллагууд бусад байгууллагуудаа манлайлан ажилласан байна.<br>-ССАЖЗЯ-аас зохион байгуулсан “Соёлын бүтээлч сарын аян”-ы хүрээнд соёлын 9 байгууллагаар дамжуулан 46 арга хэмжээг зохион байгуулж танхимаар 11926 иргэн хамрагдсан ба 35 цахим мэдээ, мэдээлэл бэлтгэн түгээж 5253 хүнд хүргэсэн байна.<br>Мөн цахим орчинд эерэг хандлагыг түгээх зорилгоор “Урлаг+Лаг байя”, “Оюун+Лаг байя”, “We Love Culture” зэрэг цуврал рийлийг бэлтгэн түгээж цахим орчинд 8,748 хүнд хүргэсэн байна. |
| 7. | 1.3.Үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 1.3.1.Байгууллага иргэдийн дунд үндэсний бичгээ эзэмших ажлыг эрчимжүүлснээ | 1.3.1.1. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх чиглэлээр олон талт үйл | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2023 | 2 | 2 | - | - | 2 | - | 100 | 2025 онд Монгол хэлний анги нийтийн чанарын уралдааныг Боловсролын газар, ерөнхий боловсролын 3 дугаар сургуулиуд хамтран 2 үе шаттай зохион байгуулж, 20 сургуулийн 6-12 дугаар |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | р Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ. | ажиллагаа зохион байгуулах | | | | | | | | | | ангийн давхардсан тоогоор 26157 сурагчид оролцсон. Уралдааны I шатны гүйцэтгэлийн дундаж 39.4 хувь, II шатны гүйцэтгэлийн дундаж 48.3 хувь, харьцуулахад 8.9 хувиар ахисан байна. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудсыг 100 хувь хос бичигт шилжүүлж, төрийн байгууллагуудын захиалгын дагуу 47 байгууллагын 800 гаруй албан хаагчийг үндэсний бичгийн сургалтад хамруулж анхан, дунд, ахисан шатны мэдлэг чадварыг олголоо. Мөн орон нутгийн "Тусгал-1" телевизтэй хамтран аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 12 дугаар ангийн сурагчдын дунд "Үндэсний бичгийн үсэглэлийн аварга-2025" уралдааныг зохион байгуулж байна. Уралдаанд төрийн болон хувийн хэвшлийн 17 сургуулийн 500 гаруй оролцож байгаа бөгөөд 12 дугаар 18-ны өдөр шалгаруулж дууСна. Уралдааныг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: ЭРҮҮЛ, БҮТЭЭЛЧ, ХӨГЖИХ ТЭМҮҮЛЭЛТЭЙ-ЭРДЭНЭТ ХҮН БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 2: ЭРҮҮЛ, ОЮУНЛАГ, ИРГЭНИЙГ БҮТЭЭНЭ** | | | | | | | | | | | | | |
| 8. | 2.1. Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна. | 2.1.1.Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | 2.1.1.1."Эрүүл хамт олон" ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, жил бүр шалгаруулан сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулах | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага | Тоо | 2023 | 81 | 83 | 10.0 | ОНТ | 92 | 9.0 | 100 | Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хүрээнд 7 арга хэмжээг салбар дундын оролцоотой хамтран зохион байгууллаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж ,Оффисын ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | байгууллагын 34 албан хаагчдад зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан. ХАБЭА-н сарын аяны хүрээнд төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Байгууллагын үйлчилгээний ажилчдын чадварыг нэмэгдүүлье– харуул хамгааллын бэлэн байдлыг хангая” уралдаанд эрүүл мэндийн салбараас төлөөлөл болон 11 хүн амжилттай оролцож, ур чадвараа нэмэгдүүлсэн. Аймгийн Нийгмийн даатгалын газрын 21 албан хаагчдад "Сэтгэцийн эрүүл мэнд", "Ажлаас халшрах хам шинж" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сэтгэл түгшилтээ хэрхэн зөв удирдах, шийдвэрлэх талаар зөвлөгөө өгч ажилласан. Эрдэнэт үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зөвлөлтэй хамтран “Эрүүл мэндийн дэмжигч байгууллага” шалгуурын талаар 27 цехийн 54 хүн, 33 цехийн дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан 66 хүнд “Эрүүл мэндийн дэмжигч ”байгууллага хөдөлгөөний талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тус тус зохион байгуулсан.Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд Орхон аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран харьяа 16 байгууллагын 800 албан хаагчдын дунд “Шүд угаах цаг” аяныг өрнүүлж цайны цагийн дараа шүд угааж хэвшсэн байгууллагыг шалгаруулж олон нийтэд сурталчилж ажилласан.<br>Тайлант хугацаанд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор 9.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан 2025 онд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хүсэлт ирүүлсэн 13 байгууллагаас |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | зэрэглэл ахиулахаар 9 байгууллага, шинээр 4 байгууллагад Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсгээс ажлын байранд дээр очиж үнэлгээ хийж, сонгон шалгаруулаа. Комиссын хурлын шийдвэрээр 4 байгууллага шинээр, 5 байгууллагыг зэрэглэл ахиулж, 4 байгууллага шалгуур үзүүлэлтийн оноонд хүрэлгүй хасагдаж үнэлэгдсэн. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч 92 байгууллагатай болсон байгаа нь өмнөх оноос 4-өөр нэмэгдсэн байна. |
| 9. | | | 2.1.1.2.“Иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгоонд хамрагдах нөхцөлийг сайжруулах | Үзлэгт хамрагдсан иргэд | Хувь | 2023 | 34 | 36 | 20.0 | ОНТ | 35.3 | - | 65 | Тайлант хугацаанд улс орон даяар зохион байгуулсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг” үзлэгт нийт хүн амын 67.7 хувь буюу 71542 иргэн хамрагдаж, улсын хэмжээнд 21 аймгаас тэргүүлж байна.<br>Тус үзлэгээр давхардсан тоогоор 83643 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдэн , 57287 хүнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 7414 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад, 11882 хүнийг лавлагаа шатлалын хяналтад авсан байна.Эрт илрүүлэг, үзлэгийн дүнд нийт 148 хавдрын тохиолдол илрүүлснээс 53.2 хувь нь эрт үедээ оношлогдсон байна.Тухайлбал ходоод,улаан хоолойн хавдрын эрт илрүүлэгт зорилтот бүлгийн 33100 иргэн хамрагдаж, 51 тохиолдлыг эрт үед нь оношлон, эндоскопийн аргаар салст хуулах EMR/ESD мэс заслыг хийж, эмчлэн хяналтад авсан. Хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгээр |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | амны хөндийн өвчлөл, насанд хүрэгчдийн дунд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл зонхилон тохиолдсон байна. 2025 онд аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн байгууллагуудаар нийт 728121 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 283573 буюу 35.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн байна.Хүүхдийн эрт илрүүлэг үзлэгт 33671 хүүхэд /88.7%/, 18-аас дээш насны 26035 хүнийг хамруулсан байна.Сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2557 (99.2%) хамрагдсан. Илрүүлэгт 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. |
| 10. | | | 2.1.1.3.“Заавал хийх товлолын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлэх | Товлолт дархлаажуулалтын хамрагдалт | Хувь | 2023 | 99 | 99 | 10.0 | ОНТ | 99.8 | 23.7 | 100 | Тайлант хугацаанд Товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 5973 хүүхдээс 5967 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99.8 хувь буюу өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Тайлант хугацаанд 525 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 49.3 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор буурсан үр дүнд хүрсэн байна. Тайлант хугацаанд дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, халдварт өвчний хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 2 ажлын хэсэг ажиллаж, 23.7 сая төгрөгийг шийдвэрлэн, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. Дархлаажуулалтын талаар иргэдэд мэдээлэл түгээх 4 удаагийн аян, 2 өдөрлөг зохион байгуулж, 1 төсөл хэрэгжүүлэн ажилласан. |
| 11. | 2.2. Өвчлөл нас баралтыг | 2.2.1.Бүх нийтийн эрүүл | 2.2.1.1.“Хувийн хэвшлийн эрүүл мэндийн | Төрийн үйлчилгээг гэрээгээр | Тоо | 2023 | 1 | 2 | - | - | 6 | 708.6 | 100 | - Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/20 тушаалаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бууруулж, хүн амаа өсгөнө. | мэндийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх | гүйцэтгүүлэх эрүүл мэндийн байгууллага | | | | | | | | | | буй хувийн эмнэлгүүдийн өдрийн эмчилгээний орыг нийт 459-аар баталж, тайлант хугацаанд 9562 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>-Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 2 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан.<br>-Тайлант хугацаанд Засаг дарга өрхийн эрүүл мэндийн 8 төвтэй анхан шатны тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж, хэрэгжилт 89,9%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,8%-иар буурсан байна.<br>-ЭМГ, сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2557 хүүхдийг хамруулж, 1710 (66.3%) хүүхдэд сэжигтэй өөрчлөлт илэрч, 1887 (73.8%) нь эмчлэн эрүүлжсэн.<br>-Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн эмнэлэгтэй гэрээ байгуулан 16-49 насны 1662 эмэгтэйг үзлэгт хамруулан лавлагаа шатлалд 152 эмэгтэйг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн эмчийн шинжилгээнд хамруулсан.<br>-“Зорилтот бүлгийн хүн амд хүргэх тусламж үйлчилгээг сайжруулъя” төслийн хүрээнд хувийн хэвшлийн 6 байгууллагатай хамтран ажилласан.<br>- Орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгэх сонгон шалгаруулалтад Уян чагнуур ХХК-ийн Бужинлхам эмнэлэг шалгарч, 29 багийн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | сульдаа, ураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг зуны сувилалд хамруулсан. -Гемодиализийн тусламж үйлчилгээний ачаалал, чирэгдлийг бууруулах зорилгоор төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд засвар үйлчилгээ, цахилгааны нөөцийн эх үүсвэрийн зардалд 678,6 сая төгрөгийг Засаг даргын аваарын зардлаас шийдвэрлэсэн байна. |
| 12. | | | 2.2.1.2. Сэргийлж болох нас баралт, осол гэмтлийн нас баралтыг бууруулахаар эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй амилуулах суурь тусламжийн чадавхыг нэмэгдүүлэх | Амь тэнссэн тусламж үйлчилгээний чадавх | Хувь | 2023 | 91 | 91.5 | 395.0 | ОНТ | 91.7 | 395.0 | 100 | Тайлант хугацаанд осол гэмтлийн шалтгаант тохиолдол 868 бүртгэгдэж, 10.000 хүн амд 78.9 байгаа нь өмнөх оны мөн үеэс 95.3 тохиолдлоор буурсан байна. Монгол улсын зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор, чиглүүлэгч багш Бямбаагийн Батбаяр агсны нэрэмжит амилуулах тусламжийн “Миний мэргэжил миний бахархал” ур чадварын тэмцээнийг Амиллуулах,яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж, нийт 6 багийн 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. Тайлант хугацаанд амиллуулах суурь тусламж үзүүлэх чадавхтай иргэд, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэх 12 удаагийн сургалтад төрийн 48 байгууллагын 498 албан хаагч, эрүүл мэндийн байгууллагын 188 эмч , эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. Аймгийн Улаан загалмайн хороо орон нутгийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Хүмүүнлэг иргэн – хөгжлийн ирээдүй” нөлөөллийн ажил, “Анхны тусламж – амь нас аварна” сургалт, дадлага ажлыг ЕБС-ын 1, 4, 8, 13, 14, 17-р сургуулиудад зохион байгуулж, сурагчдад осол, эрсдэлийн үед өөртөө болон бусдад анхны болон |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | сэтгэл зүйн тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлсэн. Тус сургалт, дадлага ажилд үе тэнгийн нөлөөлөгч 180 сурагч, дэмжигч 60 багшийг бэлтгэн, нийт 450 гаруй сурагч, багш,эцэг эхийг хамрууллаа. Түргэн тусламжийн төвийн жолооч, эмч нарын цалингийн болон шатахууны зардалд орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, тусламж үйлчилгээний чадвахийг нэмэгдүүлсэн байна.**Ингэснээр амь тэнссэн тусламж үйлчилгээний чадавх 91.7%-д хүрсэн байна.** |
| 13. | | | 2.2.1.3. БОЭТ-ийн Амбулаторийн өргөтгөлийн барилгатай болгож, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах | Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | - | 100 | 638.3 | ОНТ | 50 | 350.0 | 50 | Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Амбулаторийн 3,4 давхарт орон нутгийн 350.0 сая төгрөгийн төсвөөр их засвар хийгдэж, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй тав тухтай орчныг бүрдүүлсэн. Мөн хавдрын оношилгоо эмчилгээний төвийн их засвар 350.0 сая, гемодиализын тусламж үйлчилгээ үзүүлэх хэсгийн их засвар 543.0 сая, цахилгаан татах ажилд 320.0 сая, мэс заслын тасгийн дээврийн засварт 89.9 сая төгрөг, нийт орон нутгийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дээрх засвар үйлчилгээ 100 хувь хийгдэж, ашиглалтад орсон. БОЭТ-ийн Амбулаторийн өргөтгөл барих ажлын зураг төсвийг хийлгэж магадлан хийлгэсэн байна. |
| 14. | | | 2.2.1.4. Жирэмсний хяналтыг сайжруулах | Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хэмжээ | Хувь | 2023 | 98.5 | 98.6 | - | - | 99.0 | 10.0 | 100 | Тайлант хугацаанд жирэмсний хяналтад шинээр 1582 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 1566 буюу 99.0 хувь нь хяналтад орсон байна. Жирэмсний хяналтад 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж төрсөн ээжүүдийн хувь 94.2 хувь болж, өмнөх оноос 17.7 хувиар нэмэгдсэн байна.<br>Жирэмсний хяналтыг сайжруулах, нөхөн үржихүйн тусламж |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр олон талт үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн. Үүнд: Салбар дундын хэлэлцүүлэг 2, эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт 5, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварын үнэлгээ 1, жирэмсний хяналтыг сайжруулах 6 удаагийн сургалтад анхан болон лавлагаа шатлалын давхардсан тоогоор 98 эмч, эх баригч нарыг хамруулан чадавхжуулсан. Анхан шатлалын байгууллагын эх баригч нарыг БОЭТ-ийн Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн кабинетад, БОЭТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарыг Эх нярайн үндэсний төвийн эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэгт тус тус сэлгэн ажиллуулж чадавхжуулсан.<br>Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулах чиглэлээр:<br>- Амьдралын алтан 1000 хоног сэдэвт 4 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг 357 жирэмсэн эх, гэр бүл, төрөх тасгийн 50 ээжид биечлэн сургалт зохион байгуулж, 6 видео 7690 хандалт авсан байна.<br>-“Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд” 3 постер бэлтгэж 16,196 хандалт авсан байна. |
| 15. | | | 2.2.1.5. Эрүүл мэндийн даатгалгүй, эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгт хамруулж хэнийг ч орхигдуулахгүйгээр тусламж үйлчилгээ нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн даатгалгүй иргэдийн үзлэгт хамрагдалт | Тоо | 2023 | - | 150 | 100.0 | ОНТ | 176 | 74.3 | 100 | Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулж,18 байгууллагын 1467 хүнийг хамруулан эрүүл мэндийн даатгалын хамралт 92.5 хувь байна.<br>-Тайлант хугацаанд 4 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр 1384 хүн, цэрэг татлагаар 1241 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | залуучуудыг сургалт сурталчилгаанд хамруулснаас 50 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан. Жаргалант суманд зохион байгуулсан малчид, тариаланчдын өдрөөр 106 хүнийг сургалтад хамруулан 30 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан байна.<br>-Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 74.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан.Үүнээс эрүүл мэндийн даатгалгүй зорилтот бүлгийн 176 хүнийг үзлэг шинжилгээнд хамруулсан.<br>-2025 онд нээлттэй хаалганы өдөр, өдөрлөг, нөлөөлийн ажлын хүрээнд явуулын тусламж үйлчилгээг 5735 хүнд үзүүлснээс эрүүл мэндийн даатгалгүй 2406 хүнд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Тухайлбал цагаан тоосны нөлөөллийн бүсэд явуулын үзлэгт 2500,Иргэдийн оролцоо–Төлөөлөгчийн манлайлал өдөрлөг –525, малчдын эргэлтээр 350 хүн хамрагдан, явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлсэн байна.<br>-Эрүүл мэндийн даатгалгүй, зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хэрэгжилтийн хувь 95% байна. |
| 16. | | 2.2.2.Эмчилгээний болон амин дэмийн дэмжлэг үзүүлэх замаар эмийн зохистой хэрэглээг бий болгоно | 2.2.2.1. Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг амин дэмжүүлэх, цус цусан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах | Жирэмсэн, хөхүүл эхчүүдийн аминдэмийн хангалт | Хувь | 2023 | 16 | 16.5 | 15.0 | ОНТ | 46.1 | 20.0 | 100 | Тайлант хугацаанд нийгмийн халамж нэн шаардлагатай 535 жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд Жентли Айрон бэлдмэлийн 2 сарын хэрэглээг 100% олгож, цус багадалттай 181 (33.8%), эх барихын ужиг дурьдатгалтай 86 (16.1%),эх барихын бус бусад эмгэгтэй 85 (15.9%), нийгмийн халамж нэн шаардлагатай 111 (20.7%), хөхүүл 72 (13.5%) эхэд олгон, хэрэглээг цусны давтан шинжилгээгээр хянаж, жирэмсэн эхийн цус багадалтын түвшин өмнөх оны мөн үеэс 0,3%-иар буурсан байна.Жирэмсний хяналтад байгаа 755 эхээс 613 буюу 81,2%-ийг олон найрлагат бичил тэжээлийн амин дэмийн хангалтад хамруулсан байна.<br>Тайлант онд БОЭТ-ийн Цусны салбар төв нь 10 нэр төрлийн 1504 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 17%-аар өссөн бөгөөд бүхэл цусны 668 донороос 668 нэгж цус цуглуулсны 540 суурин, 128 явуулын хэлбэрээр авсан байна. Орон нутгийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвхи санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулж, 8 байгууллагын 287 донор цус бэлэглэж, 7 байгууллагын 142 хүнд донорын ач холбогдлыг таниулах мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж, өмнөх оны мөн үеэс 37 донороор нэмэгдсэн байна. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17. | | | 2.2.2.2. Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх | Дэмжлэгт хамрагдалт | Хувь | 2023 | 69.2 | 69.4 | 100.0 | ОНТ | 89.5 | 120.0 | 100 | 2025 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөл хорт хавдартай 213 иргэнд нийт 120.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгосон байна. 2025 онд шинээр батлагдсан 238 хавдрын тохиолдлын 89.5 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна. Хорт хавдартай иргэдэд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлуулсан. |
| 18. | 2.3. Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг нэмэгдүүлнэ. | 2.3.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлнэ | 2.3.1.1. Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлыг бэхжүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулан тогтвортой үйл ажиллагааг дэмжих | Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилт | Хувь | 2023 | 95.1 | 95.2 | - | - | 95.7 | - | 100 | Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн тоо 2020 онд 77, 2021 онд 81, 2022 онд 85, 2023 онд 80, 2024 онд 76, 2025 оны жилийн эцсийн байдлаар 74 эмийн сан, 8 Эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 онд 1-р зэрэглэлийн эмийн сан 52, 2025 оны байдлаар 46 болж 11%-иар буурсан, 2-р зэрэглэлийн эмийн сан 25-аас 28 болж 12%-иар нэмэгдсэн.Ингэснээр хотын төвд байрлалтай эмийн сангийн төвлөрөл буурч, гэр хороололд байрлах эмийн сангийн тоо өсөж, алслагдсан багийн иргэдэд хүргэх эм зүйн тусламж үйлчилгээ ойртсон байна.Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээтэй хөнгөлөлттэй үнээр эм олгодог эмийн сан 2020 онд 28 байсан бол 2025 онд 53 болж 52,8%-аар нэмэгдсэн байна. Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт 2021 онд дунджаар 88.9% 2022 онд 88.1%, 2023 онд дунджаар 93.5%, 2024 онд 94.2%, 2025 онд 94.8% байгаа нь 2020 онтой харьцуулахад 6.8%-аар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/108 тоот тушаалаар “Эмийн чанар, аюулгүй байдлын орон тооны бус салбар зөвлөл” 5 хүний бүрэлдэхүүнтэй |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | байгуулагдан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Эмийн чанар, эмийн гаж нөлөөний сургалтад 86 эрхлэгчийг хамруулж, “Антибиотик эмийг жороор олгоё” 3 сарын аянд 71 эмийн сан нэгдэн антибиотикийг 100% жороор олгон, 111 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулан гарын авлагаар хангаж, антибиотикийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөмжийг 2516 хүнд өгсөн байна.Тайлант хугацаанд стандартын шаардлага хангаагүй 3 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалсан.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас ирсэн албан тоотын дагуу Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжаар 2025 оны 09 дүгээр сарын 17-27-ны хооронд 10 хоногийн аян зохион байгуулж, эмийн зохистой хэрэглээтэй холбоотой иргэдэд хандсан 8 брошюр, цахимд 10 мэдээлэл хүргэсэн.Сэтгэцэд нөлөөт эмийн 3786 жорыг 13 байгууллагад, мансууруулах эмийн 557 жорыг 3 байгууллагад тус тус дугаарлан олгосон. Анзаар-2 аяны хүрээнд ЭМГ, Тагнуулын газар, Цагдаагийн газар хамтран бүх нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудад хяналт хийсэн байна. Хяналтаар 6 байгууллагад зөрчил шалган шийдвэрлэж, бүх эмийн сангуудад хяналтын дүгнэлт, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. |
| 19. | | | 2.3.1.2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай лабораторийн болон бусад тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах | Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2023 | 96 | 96.1 | 100.0 | ОНТ | 96.5 | 173.0 | 100 | Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5092:2017 стандартын дагуу 8 багц 69 төрөл тоног төхөөрөмж байх шаардлагатайгаас хангалтын хувь 96.5-д хүрээд байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн лабораторийн шинжилгээнд бамбайн даавар, |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | витамин Д, глюкозын гурван сарын дундаж үзэж, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. 2025 онд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, лабораторийн тусламж үйлчилгээний нэр төрлийг сайжруулах чиглэлээр нийт улс, орон нутгийн 173.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, машин олгосон байна. Орон нутгийн 141.5 сая төгрөгийн санхүүжилтээр:<br>Шарлагын аппарат-Мөнхсүндрэл, Анхны Оч Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат -Анхны Оч<br>Мобайл технологи-Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв Жаргалант суманд иммунологийн аппарат, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдэл, поток, искра аппаратууд нийлүүлэгдсэн байна.Улсын төсвийн 31.5 сая төгрөгийн өртөг бүхий ECG S120 эрт илрүүлэг хийх зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 9 сум, өрхийн эрүүл мэндийн төвд олгосон байна. |
| 20. | | | | 2.3.1.3. Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх | Хариу арга хэмжээний чадавх, ЭМБ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт | Хувь | 2023 | 95 | 95.2 | 30.0 | ОНТ | 95.6 | 190.0 | 100 | Тайлант хугацаанд Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын дагуу томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед ЭМГ, ЭМБ-ууд нь Тохиолдол удирдлагын тогтолцоонд 2 удаа шилжин хариу арга хэмжээнд салбар дундын оролцоог хангаж, эрсдэлийн үнэлгээг 6 удаа хийн, өрхийн эрүүл мэндийн төвүүд уртасгасан цагаар ажиллаж, хүүхдийн тасгийн орыг 150-д хүргэж дэлгэн хариу арга хэмжээний хэрэгжилт 95.6 хувьд хүрсэнээр томуугийн тархалтын түвшнийг "Аймгийн" түвшнээс "Алаг цоог" түвшинд 14 хоногийн дотор буурүулсан байна. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах хүрээнд аймгийн |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | | Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээ, эрсдэлийн харилцаа холбоог мэдээллийг идэвхжүүлэн ажилласан. 2025 онд улаанбурхан өвчний сэжигтэй 86 тохиолдол бүртгэгдэн, 66 тохиолдол батлагдаж, сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 347 /96.9 хувь/ хүнийг дархлаажуулалтад хамруулан хариу арга хэмжээг шуурхай авч ажилласнаар 2025 оны 9 сараас хойш он дуустал хугацаанд улаанбурхан өвчний сэжигтэй, батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна.<br>ЭМГ-ын гамшгийн нөөц 12 нэр төрлийн 4.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, 4.6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй байна. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо” сургалтад аймгийн ЗДТГ, ОБГ, ЦГ-ын удирдлага, мэргэжилтнүүд, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллага, хүүхдийн байгууллагын эмч зэрэг нийт 145 хүнийг хамруулан чадавхжуулсан. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21. | | | 2.3.1.4. БОЭТ-ийн оношилгоо, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх | Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | Хувь | 2023 | 95 | 95.5 | 1,100.0 | УТ, Гадаад Зээл Тусламж | 96 | 4,897.0 | 100 | Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96 хувьтай байгаагаас дэвшилтэт технологийн тоног төхөөрөмж 20 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт 600 гаруй тоног төхөөрөмжийг тусламж үйлчилгээнд ашиглаж байна.<br>-Тайлант хугацаанд БОЭТ-ийн Хавдрын оношилгоонд 602 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэн оношилгооны чадавх нэмэгдсэн.<br>-БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товлолын үйл ажиллагааг цахимжуулахад аймгийн төсвөөс 75 сая төгрөгийг зарцуулж, амбулаторийн тасгийн цахим бүртгэлийн системийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн.<br>-Аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх Sterilwave-100 төхөөрөмжийг БОЭТөвд суурилуулан аймгийн хэмжээний ЭМБ-уудын аюултай хог хаягдлыг устгалд оруулж байна.<br>-Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүлээн авах хэсэгтэй Халдварт, яаралтай тусламжийн тасгуудад орон нутгийн төсвөөс улаанбурханы хариу арга хэмжээнд 130.0 сая төгрөгөөр нэн шаардлагатай 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг шийдвэрлэн чадавхийг нэмэгдүүлсэн.<br>-Орон нутгийн хөрөнгө оруулалтаар унтуулгын аппарат 500,0 сая, газлазм аппарат 150,0 сая, өвчтөн зөөвөрлөх шат, комьпютер зэрэг нийт 897.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн нээлттэй тендер зарлагдаж, 100 хувь нийлүүлэгдэн ашиглагдаж байна.<br>-Төвлөрлийг сааруулах зорилгоор орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Үндэсний баг Орхон аймагт 2 удаа |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | ажиллан ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөхний хавдар,хими эмчилгээ, зүрх судас, элэг цөс, тархи мэдрэлийн судсан дотуурхи оношилгоог нийт 534 хүнд хийж, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор 125 хүнийг хамруулан, хамтарсан үзлэг оношилгоо, хагалгааг хийж чадавхжуулан нутагшуулсан байна.Үүнд:<br>-Элэгний мэс засал 4,ангио мэдрэлийн TACE 11 мэс заслыг хийж, тайлант хугацаанд орон нутагт бие дааж элэг тайрах мэс засал 1, нойр булчирхайн мэс засал 1, ходоод тайрах мэс засал-2, хөхний хавдрын мэс заслын 3 тохиолдол амжилттай хийгдсэн байна.<br>-Үндэсний багийн эмч нартай хамтран 14 тархины судасны ангиографийн оношилгоо хийгдсэнээс тархины судасны аневризмийн 6, гүрээний судасны бөглөрөл ба нарийслын 1 тохиолдол тус тус шинээр оношлогдсон.<br>- Орон нутагт нэвтрээгүй зарим мэс заслыг нэвтрүүлэх зорилгоор ШУГТЭ, УХТЭ-т хүсэлт хүргүүлэн гүрээний судасны бөглөрөл, нарийсалд стент тавих 1, судсан дотуур аневризм засах 1 мэс заслыг хамтран орон нутагт амжилттай хийгдсэн байна.<br>-Доод мөчдийн их өнгөц венийн судсыг сугалж авах мэс заслын 7 тохиолдлыг бие даан амжилттай хийсэн. Үүнд 2 хүнд элэгний хавдрын судас бөглөх эмчилгээ, 3 хүнд элэгний хавдрын мэс засал, 30 хүнд хөхний үзлэг, оношилгоо, 3 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хүнд хөхний мэс засал хийгдсэн. |
| 22. | 2.4.Эрүүл, аюулгүй, баталгаат орчныг бий болгоно: | 2.4.1.Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2.4.1.1. Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Хотын хэмжээнд одоо байгаа үерийн хамгаалалтын сувгийн хэмжээ | Км | 2023 | 76 | 76 | 2500.0 | ОНТ /Гадаад зээлийн төлөлт/ | 78.6 | - | 100 | Орхон аймаг Баян-Өндөр сумано ЕСБХБ банктай хамтран хэрэгжүүлж буй "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн хүрээнд хийгдэх үерийн далан, суваг барих ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын Хунан Индастриал Экуйдмент Инсталэйшн ХХК шалгарч 9 байршлын 12.8 км инженерийн хийцлэлтэй үерийн далан, 14000м3 багтаамжтай үерийн усан сан барихаар гэрээ байгуулан гүйцэтгэж байна. 2025 онд Баян-Өндөр сумын хэмжээнд 5 байршилд хийгдэж байгаа ба одоогийн байдлаар суваг-A 60 хувь, суваг-D 70 хувь, суваг-E 20 хувь, суваг-B 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна.<br>Орон нутгийн төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дэнж багт-300м, Уртынгол багт 320м, Их залуу багт 350м, 2а хороололд 320м, БаянОвоот багт 250м, Жаргалант суманд 1100м урт үерийн хамгаалалтын болон борооны ус зайлуулах сувгийн ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулаад байна.<br>Мөн хотын хэмжээнд авто замын 61 засвар шинэчлэлтийн хийгдсэн ажлын хүрээнд 6.4 км урт үерийн болон гадаргын ус зайлуулах сувгийн ажил хийгдсэн. |
| 23. | | | 2.4.1.2. Хотын доторх үерийн далан сувагт засвар шинэчлэлт хийх, шаардлагатай газар шинээр суваг хийж, автомашины орц, гарц хийх | Хийгдсэн орц, гарц, ухсан үерийн сувгийн хэмжээ | Км | 2023 | 34 орц гарц, 11.2 км үерийн суваг | 68 орц гарц, 72.8 км үерийн суваг | 200.0 | ОНТ | 70 орц гарц, 47.8 км үерийн суваг | 65.0 | 100 | Гэр хорооллын үерийн сувгийн цэвэрлэгээг Баян-Өндөр сум 3-р сараас эхлэн хийж гүйцэтгэн 5 удаагийн цэвэрлээг хийж, нийт 47.8 км шороон сувгийг сэргээж ухаж, автомашины 70 орц, гарц шинээр хийж, давхардсан тоогоор 306 орц, гарцыг засварласан байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24. | | 2.4.2.Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ. | 2.4.2.1. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги болон иргэдийн дунд сургалт зохион байгуулах | Зохион байгуулсан сургалт | Тоо | 2023 | 135 | 140 | - | - | 321 | - | 100 | Иргэд, олон нийтийн гамшгийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гамшигтай тэмцэх, хариу арга хэмжээ авах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 2025 оны байдлаар нийт 321 удаагийн сургалтыг 14074 иргэнд , удирдах албан тушаалтны сургалт-2 гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн сургалт 85, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдад 134, иргэний сургалт-21 сургуулийн өмнөх насны хүүхдэд -12, их дээд сургууль, оюутан сурагчдад-22, ЕБС- ахлах анги -19, дунд анги-9, бага ангийн сурагчдад-4, цэргийн дүйцүүлэх албанд-2, сайн дурын иргэнд-10, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд-3 удаа зохион байгуулсан. Дээрх сургалтыг цахим бүртгэлд тухай бүрд бүртгэж ажилласан. |
| 25. | | | 2.4.2.2. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд болон алба мэргэжлийн ангиудын дунд уламжлалт тэмцээн, уралдаан зохион байгуулах | Хамрагдсан алба мэргэжлийн анги, сургууль | Тоо | 2023 | Алба мэргэжлийн ангиудын 10 баг, 15 сургууль | 15 алба мэргэжлийн анги, 18 сургууль | 18.0 | ОНТ | 18 алба мэргэжлийн анги 17 баг | 10.0 | 100 | Орхон аймгийн Засаг даргын 2025 оны А/318 дугаар захирамжаар "Аврагч-2025" тэмцээнийг Төрийн болон хувийн хэвшил, мэргэжлийн анги албад, анхны тусламжийн нөхөрлөлүүдийн дунд 2025 оны 05 дугаар сард зохион байгуулж, нийт 18 нөхөрлөлийн 144 ажилтан, албан хаагчид хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/807 дугаар захирамжаар “Өсвөрийн аврагч-2025” тэмцээний удирдамж, хөтөлбөрийг батлуулан 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Онцгой байдлын газар, Улаан загалмайн хороо, Боловсролын газартай хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Тэмцээнд нийт 17 сургуулийн 49 сурагчид хамрагдаж, өрсөлдөн, шилдгээ тодлууллаа. Багш нарын ажил хаялттай холбоотой оролцоо |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | муу байсан. |
| 26. | | | 2.4.2.3. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, үерийн далан суваг шуудууг сэргээн засварлах, тэмцэх чадавх болон техник хэрэгслийг нэмэгдүүлэх | Тенник хэрэгслийн хангалт | Сая.төг | 2023 | 188.3 | 100.0 | 100.0 | ОНТ | 199.5 | 199.5 | 100 | Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 223 өрхийн 795 иргэн үерт өртөх эрсдэлтэйг тогтоож, цахим хуудсаар 4 төрлийн сэрэмжлүүлэг хүргэн 11384 иргэнд хүргэсэн. 5 багийн нутаг дэвсгэрт байрлах 2063.21 метр урттай далангаас 702 м³ шороо зөөвөрлөж, нөхөн сэргээлт хийсэн.<br>Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хүрээнд 256 ААНБ-ын самбарт зөвлөмж байршуулж, 2932 иргэнд биечлэн мэдээлэл өгч, цахим хуудсаар 11 төрлийн мэдээллийг 56,618 иргэнд хүргэсэн.<br>Говил, Уурхайчин багт үүссэн халиаг арилгах зорилгоор нийт 2,100 гаруй метр далан байгуулж, 5,390 м³ мөсийг цэвэрлэн ажилласан. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 199.5 сая төгрөгийг шийдвэрлүүлэн Гамшиг, ослын үед гал унтраах бодис зөөвөрлөх, тээвэрлэхэд ашиглах 71.5 сая төгрөгийн өртөг бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмж, 28.0 сая төгрөгөөр хөдөлгөөн, дулаан мэдрэгчтэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж тус бүр нь 25 сая төгрөгийн өртөг бүхий 4ш дулаан, хөдөлгөөн мэдрэгчтэй 2 нүдний дуран худалдан авч гамшгийн үед үүрэг гүйцэтгэх чадавхаа нэмэгдүүлсэн. |
| 27. | | | 2.4.2.4. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд хяналт хийж бүртгэлжүүлэх | Хянасан тайлангийн тоо | Тоо | 2023 | 7 | 9 | 10.0 | ОНТ | 15 | - | 100 | Аж ахуйн нэгж байгууллагын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний 15 тайланг хянаж 13 тайланг баталгаажуулсан, Музей, ХХААГ-ын тайлан сайжруулалт хийгдэж ирүүлээгүй байна, тусгай зөвшөөрөлтэй 5 аж ахуйн нэгжийн хийсэн нарийвчилсан үнэлгээний 14 тайланг хянаж, 3 тайланг дахин сайжруулалт хийлгэхээр буцааж, 11 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | тайланг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргуулахаар Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэн ажиллалаа. |
| 28. | 2.5.Эрүүл, баталгаат хүнсний хэрэглээг хангана | 2.5.1.Хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана. | 2.5.1.1. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэрлэгчдийн тоог 1.5 дахин нэмэгдүүлэх | Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн аж ахуйн нэгж | Тоо | 2023 | зохистой /д 300 АДШЭЦХ - 8 | зохистой /д 310 АДШЭЦХ-12 | 45 | УТ | зохистой /д 336 АДШЭ ЦХ-12 | - | 100 | 2025 онд 6 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 94 хүнсний чиглэлийн үйлчилгээ, нийт 100 үйлдвэр, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгон баталгаажуулснаар өссөн дүнгээр нийт 25 аж ахуйн нэгж, иргэний /45.4 хувь/ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 405 /88.9 хувь/ хүнсний чиглэлийн үйлчилгээ тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байна. Үйлдвэр, үйлчилгээнд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах дотоод хяналтын тогтолцоо, зохистой дадлыг хэрэгжүүлэх арга зүйгээр хангаснаар 60 цэгт стандартын хэрэгжилт хангалттай түвшинд /81 хувиас дээш/ хүргэж гэрчилгээжүүлсэн, өссөн дүнгээр 501 цэг тохирлын баталгаатайгаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, 336 буюу 71.4 хувь нь стандартыг хангалттай түвшинд хэрэгжүүлсэн байна.<br>2025 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2 хоол үйлдвэрлэлд HACCP тогтолцоо хэрэгжүүлж байгаа бөгөөд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн нэг, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж сургууль цэцэрлэгт нийлүүлдэг 2 аж ахуйн нэгжид аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын (HACCP) тогтолцоог \ нэвтрүүлж эхлүүлснээр өссөн дүнгээр 12 үйлдвэрлэлд хэрэгжүүлж байна. Үүнээс 3 байгууллага гэрчилгээжсэн, 4 байгууллага гэрчилгээжих шатанд, 1 байгууллага аудитын шатанд, 3 байгууллага эхлүүлэхээр ажиллаж байна. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **29.** | | | 2.5.1.2. Хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэн, баталгаажуулалтын төвшнийг нэмэгдүүлэх | Баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлчилгээ | Хувь | 2023 | 44 | 48 | 12 | ОНТ | 85.6 | - | 100 | 2025 онд хүнсний чиглэлийн 195 үйлчилгээ, 25 үйлдвэр, нийт 220 үйлдвэр, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгон баталгаажуулснаар өссөн дүнгээр нийт 43 аж ахуйн нэгж, иргэний /46,7 хувь/ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 448 /93,0 хувь/ хүнсний чиглэлийн үйлчилгээ, нийт 491 цэг тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байгаа нь 85.6 хувийг эзэлж байна. |
| **30.** | | | 2.5.1.3. Тохирлыг илэрхийлэх чанар, аюулгүй байдлын тэмдэгтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | “Баталгаажсан бүтээгдэхүүн“ тэмдэгтэй байгууллага /бүтээгдэхүүн, “Баталгаажсан үйлчилгээ“ - тэмдэгтэй байгууллага /бүтээгдэхүүн, “Аюулгүйн тэмдэг”-тэй байгууллага /бүтээгдэхүүн | Тоо | 2023 | 5/15<br>5/5<br>1/12 | 10/25<br>10/10 2/15 | 15 | ОНТ | 11/86,<br>17/19,<br>2/19 | - | 100 | Энэ онд талх, нарийн боовны 2, мал төхөөрөх болон мах боловсруулах 2, хивс, ноосон-барилгын дулаалгын материал, эсгий, ээрмэл бүтээгдэхүүний 1, сүү, сүүн бүтээгдэхүүний 1, пивоны 1, хэрчсэн гурилын 1 үйлдвэр, нийт 8 үйлдвэрийн 11 нэр төрлийн 86 нэрийн бүтээгдэхүүнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэг, 10 аж ахуйн нэгжийн 11 үйлчилгээнд “Баталгаажсан үйлчилгээ" тэмдэг хэрэглэх эрх тус тус олгосон байна.<br>Аймгийн хэмжээнд "Баталгаажсан бүтээгдэхүүн" тэмдэгтэй 18 байгууллагын 31 нэр төрлийн 247 бүтээгдэхүүн, "Баталгаажсан үйлчилгээ" тэмдэгтэй 5 нэр төрлийн 17 аж ахуйн нэгжийн 19 үйлчилгээ байна.<br>Засгийн газраас баталсан "Техникийн зохицуулалт"-ын шаардлагыг хангаж аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг бүхий мал төхөөрөх, боловсруулах 3, мах, махан бүтээгдэхүүний 6, сүүний 2, бялуун бүтээгдэхүүний 6, нийт 17 иргэн, аж ахуйн нэгжийн цех, үйлдвэр байгаагаас тохирлын үнэлгээнд хамрагдсан "Жүр үр" ХХК аюулгүйн тэмдгийг 12 нэрийн бялуун бүтээгдэхүүнд, "Баяжуулагч-Одод" ХХК аюулгүйн тэмдгийг 7 нэрийн сүү, сүүн бүтээгдэхүүнд хэрэглэх |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | эрх авч, нийт 2 аж ахуйн нэгжийн 19 бүтээгдэхүүн аюулгүйн тэмдэгтэйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна |
| **31.** | | | 2.5.1.4. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг мөрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах (HACCP) болон ISO:22000 стандартыг үйлдвэрүүдэд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Сургалтад хамрагдсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллага, иргэн | Тоо | 2023 | 20/20 ,8, 350 | 25/25 , 12, 380 | 50.0 | ОНТ | 24/38, 12, 413 | 25.0 | 100 | Аймгийн хэмжээнд Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 стандартыг хэрэгжүүлж гэрчилгээжсэн 3 аж ахуйн нэгж, Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (HACCP) буюу MNS CAC /RCP 1:2003 стандартыг хэрэгжүүлэн гэрчилгээжсэн мал төхөөрөх, мах боловсруулах 3 үйлдвэр байна.<br>Аймгийн Засаг даргын 2024 оны А/353 дугаар захирамжийн дагуу хүнсний боловсруулах 5 үйлдвэрт Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (HACCP), талх, нарийн боовны нэг үйлдвэрт ISO 22000 стандарт нэвтрүүлсэн. Үүний үр дүнд: HACCP тогтолцоо нэвтрүүлсэн “Баяжуулагч-Одод” ХХК, “Билгүүн-Өглөө” ХХК, “Эрдэнэт-Өег” ХХК гэрчилгээжсэн.<br>“Ранчо” ХХК HACCP тогтолцооны гэрчилгээжүүлэлтийн шатанд байна. ISO 22000 стандарт нэвтрүүлсэн.Тэмүүжин-Оргил ХХК -ийн хэрэгжүүлэлт дуусах шатанд байна.<br>2025 онд Аймгийн Засаг даргын А/473 дугаар захирамжийн хүрээнд Хөдөө аж ахуйн зохистой дадал (GAP) нэвтрүүлсэн 1 аж ахуйн нэгж, сургууль, цэцэрлэгт, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг 2 үйлдвэрт HACCP тогтолцоо нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн нь хэрэгжүүлэлтийн үе шатыг дуусгаад хяналтын үе шатанд байна. “Эрдэнэт -Үйлдвэр” ТӨҮГ бие даан хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 2 цэгт ISO 22000 стандарт нэвтрүүлснээр нийт 12 байгууллага аюулгүй байдлыг хангах тогтолцоо хэрэгжүүлж байна. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Удирдамжийн дагуу Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005:2023 стандартын хэрэгжилтийг үнэлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний чанар аюулгүй байдалд үнэлгээ хийж стандартын шаардлага хангуулахаар Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Тогоочдын холбоотой хамтарсан үнэлгээг ерөнхий боловсролын 22 сургуулийн 26 хоол үйлдвэрлэлд тохирлын үнэлгээ хийж, зохистой дадлыг хангуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч сургалт, хэлэлцүүлэгт 75 ажилтан оролцууллаа.<br>Захирамжийн хүрээнд HACCP болон ISO 22000 стандартын сургалтыг 2 удаа, тогтолцооны аудитын 1 сургалт зохион байгуулж 25 аж ахуйн нэгжийн 38 ажилтан хамрагдсан. 2025 оны 10-р сарын 09-нд Уурхайчин соёлын ордонд хүнсний чиглэлийн 270 гаруй аж ахуйн нэгжийг хамруулсан “Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон зохистой дадал (GMP, GHP) хэвшүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж 300 орчим төлөөлөл хамрагдсан. |
| **32.** | | | 2.5.1.5. Сорьцын хяналт хэрэгжүүлэх жин хэмжүүр, сорьц тодорхойлох рентген багаж авч, ажлын тогтолцоог сайжруулах | Арилгасан зөрчил | Хувь | 2023 | 0 | 100 | 30.0 | ОНТ | 100 | - | 100 | Сорьцын хяналт хэрэгжүүлэх жин хэмжүүрийг авч хяналт шалгалт хийхэд ашиглаж байна. Үнэт эдлэлийн жингийн хувьд зөрчил илрээгүй байна.<br>Сорьцын хяналтын газарт авсан сорьц тодорхойлох рентген багажаар сорьцын баталгаанд ороогүй 4 иргэний<br>234 ширхэг бүтээгдэхүүнийг хамруулж шинжлүүлэхэд зөрчил илрээгүй байна. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | 2.6.Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчин сайжирруулна | 2.6.1.СӨББ, ЕБС-ийн хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын чанрыг дээшлүүлнэ | 2.6.1.1. Стандартын шаардлага хангасан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх | Баригдаж буй сургууль, цэцэрлэг | Тоо | 2023 | 6 | 9 | 9000.0 | УТ, ОНТ | 9 | 16917.3 | 100 | 2025 оны улс болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарт 9 барилгын төсөл арга хэмжээ хэрэгжсэн. Үүнд: дотуур байрны барилга-1, 150 ортой цэцэрлэгийн барилга -1, цайны газрын өргөтгөлийн барилга - 1, 250 суудалтай сургуулийн барилга-2, 960 суудалтай сургуулийн барилга - 2, 320 суудалтай сургуулийн барилга -2 тус тус байна. Тайлант хугацаанд 8 дугаар сургуулийн 320 хүүхдийн суудалтай өргөтгөлийг ашиглалтад оруулж, Политехник коллежийн 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг хүлээн авсан. 3 дугаар сургуулийн 960 хүүхдийн суудалтай хичээлийн байрны барилгыг 2026 оны 01 дүгээр сарын 01 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад хүлээн авахаар төлөвлөж байна. Мөн орон нутгийн төсвийн 282.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 15-р сургуулийн гал тогооны өргөтгөлийн барилга баригдаж ашиглалтад орсон байна. |
| **34.** | | | 2.6.1.2. Сургууль, цэцэрлэгийн барилгад засвар хийх ажлыг үе шаттайгаар хийж, боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | Засвар үйлчилгээ хийгдсэн сургууль, цэцэрлэг | Тоо | 2023 | 10 | 10 | 2000.0 | ОНТ | 61 | 25,024.5 | 100 | 2025 онд орон нутгийн төсвийн 5,971.1 сая төгрөгийн оруулалтаар засвар үйлчилгээ хийгдэхээр төлөвлөсөн. Үүнд ;<br>**Аймгийн төсөв: /нийт 4,050.1 сая/**<br>• Согоот баг.Баян-Өндөр сумын 14-р сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах – 300.0 сая<br>• Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг халаалтын нүүрстөрөгч багатай эх үүсвэртэй холбох / орон нутгийн оролцоо/-750.0 сая<br>• 24-р цэцэрлэгт хэсэгчилсэн засвар хийх-196.0 сая<br>• Оюу цэцэрлэгийн гадна |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | цахилгааны ажил шинээр хийх - 26.5 сая<br>• 7-р сургуулийн спорт заалны шалыг засварлах -120.0 сая<br>• 15 дугаар сургуулийн гал тогооны өргөтгөлийн барилга барих-282.0 сая<br>• Шанд багийн 17-р сургуулийн халаалтын системийг хийн зуухаар шинэчлэх / нэмэлт ажил/-89.0 сая<br>• 5 дугаар сургуулийн их засвар, сургалтын байрны зүүн жигүүрийн халаалтын систем засварлах-284.0 сая<br>• 9 дүгээр цэцэрлэгт засвар хийх-250.0 сая<br>• 1 дүгээр сургуулийн хичээлийн 1-р байрны цахилгаан, сантехникийн их засвар хийх-300.0 сая<br>• 1 дүгээр цэцэрлэгийн гадна талд дулаалгатай фасад хийх-450.0 сая<br>• 18 дугаар сургуулийн дээвэр засварлах-131.9 сая<br>• 20 дугаар сургуулийн гадна, дотно камержуулалт хийх-155.3 сая<br>• Дэгдээхэй цэцэрлэгийн гадна талбайн тохижилт хийх-350.0 сая<br>• Зэст баг. 21 дүгээр цэцэрлэгийн гадна ИШС шинэчлэх ажил -295.4 сая<br>• Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28 дугаар цэцэрлэгийн барилгын нэгдсэн бохирын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх / НҮБ-тай хамтран хэрэгжүүлэх/-70.0 сая, /нийт 4,050.1 сая/<br>**Баян-Өндөр сумын төсөв: /нийт-1,306.0 сая/**<br>• Дэгдээхэй цэцэрлэгийн дээврийн засвар хийх-179.0 сая<br>• 16-р сургуулийг өргөтгөлтэжй холбох хүзүүвчний |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | засвар хийх-169.8 сая<br>• 22-р цэцэрлэгийн хүүхдийн биеийн тамирын талбай байгуулах-19.1 сая<br>• 23-р цэцэрлэгт хүүхдийн тоглоотын талбай байгуулах-120.0 сая<br>• 1-р цэцэрлэгийн цонх шинэчлэх-343.6 сая<br>• 17-р сургуулийн хичээлийн 2-р байрны хаявч болон урд хэсгийн талбай засварлах-40.0 сая<br>• 21-р цэцэрлэгийн цонх шинэчлэх-133.0 сая<br>• Оюу цэцэрлэгийн гадна тохижилт-112.8 сая<br>• Оюу цэцэрлэгийн фассад засварлах-188.7 сая<br>**Жаргалант сумын төсөв: /Нийт 615.0 сая/**<br>• Цэцэрлэгийн бохирын шугам солих урсгал засвар хийх-140.0 сая<br>• ЕБС-ийн их засвар /инженерийн босоо хэвтээ шугам солих/ -350.0 сая<br>• Мэдээлэл зүйн танхимын их засвар-80.0 сая<br>• Дотуур байрнаас ЕБС-ийн үүд хүртэл явган зам хийх -45.0 сая<br>Мөн 2025 онд аймгийн Засаг даргын "Болзошгүй аваарын зардал"-аар давхардсан тоогоор 61 сургалтын байгууллагад сантехникийн шугам, дээвэр, цонх, хаявчны засварын 79 ажлыг 19,053.4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэснээр төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдэд тулгамдаад байгаа дулаан алдагдал, сантехникийн шугамын элэгдэл, цоорол, эвдрэл гэмтэл, дээврийн дусаал зэрэг олон хүндрэлтэй асуудлууд бүрэн шийдвэрлэгдэж багш, сурагчид маань илүү тохилог, таатай, дулаахан орчинд хичээллэх |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | боломж бүрдээд байна. |
| **35.** | | | 2.6.1.3. СӨББ, ЕБС-ийн ачаалал, ээлжийн коэффицентийг бууруулж, анги дүүргэлтийг стандартад нийцүүлэх. | ЕБС-ийн 1 бүлэгт ногдох хүүхэд | Тоо | 2023 | 32.1 | 35-аас хэтрүүлэхгүй | - | - | 33.7 | - | 100 | Ерөнхий боловсролын 24 сургуулийн 827 бүлэгт 27932 суралцагч суралцаж, бүлэг дүүргэлтийн дундаж 33.7 байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудаас бүлэг дүүргэлтийн дундаж аймгийн дунджаас доогуур бүлэг дүүргэлттэй 11 сургууль байгаа нь нийт төрийн өмчийн сургуулийн 64.7%-ийг эзэлж 12.1 хувиар өссөн ба ЕБС-ийн ээлжийн коэффициент 1.6 байна. |
| **36.** | | | 2.6.1.4. Өмчийн бүх хэлбэрийн ЕБС, СӨББ-ын сургалтын чанарыг сайжруулж, ЭЕШ-ын чанарыг ахиулах | Сургалтын чанар | Хувь | 2023 | СӨББ-65.78<br>ЕБС-78.2 | СӨББ-66.5<br>ЕБС- 79.2 | - | - | СӨББ-67.52<br>ЕБС-81.2 | - | 100 | Тайлант хугацаанд 15 настай сурагчдын PISA олон улсын үнэлгээний шалгалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын 20, 14, “Билигт өргөө”, “Эрдмийн сан” сургууль, Политехникийн коллеж зэрэг нийт 5 сургалтын байгууллагын 197 сурагч түүвэрлэгдэж, 186 сурагч шалгалт, асуулгад хамрагдсан. 2024-2025 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтын дүн, сурлагын үзүүлэлт аймгийн дунджаар 81.2%-тай байна.<br><br>Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг БҮТ-өөс 2025 онд зохион байгуулаагүй бөгөөд тус үнэлгээний 2024 оны улсын дундаж 69.48%, орон нутгийн дундаж 69.97%, аймгийн дундаж 67.52%-тай байна. Аймгийн хэмжээнд хүүхдийн 37 цэцэрлэгийн 2539 хүүхэд сургуульд бэлтгэгдэх үнэлгээнд хамрагдаж, хүүхдийн 22 цэцэрлэг улс, аймаг, орон нутгийн дунджаас дээгүүр үнэлэгдэж, хүүхдийн 15 цэцэрлэг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | доогуур үнэлэгдсэн байна. |
| **37.** | | | 2.6.1.5. ЕБС, СӨББ-ыг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшлоор хангаж сургалтын орчныг сайжруулах | Шаардлагатай хөрөнгө оруулалт хийгдсэн сургалтын байгууллага | Тоо | 2023 | 48 | 50 | 1000.0 | УТ, ОНТ | 59 | 1,094.6 | 100 | 2025 онд орон нутгийн төсвийн 1,094.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангасан. Үүнд:<br>1. Ерөнхий боловсролын сургуулиудад шинээр байгуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд тоног төхөөрөмж худалдан авах-100.0 сая<br>2. Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах -232.9 сая<br>3. Ерөнхий боловсролын 6-11-р ангиудад 1000 ном төсөл уншлагын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай худалдан авалт хийх-250.0 сая<br>4. 13 дугаар сургуулийн Монгол хэлний кабинетад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах-20.0 сая<br>Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 17 сургалтын байгууллагад 377.8 сая төгрөгийн, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 2 сургалтын байгууллагад 2 сургалтын байгууллагад 113.9 сая төгрөгийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн байна.<br>Тайлант хугацаанд аймгийн Боловсролын газраас "Мобинэт" ХХК-тай хамтран ажиллаж, тус компанийн интернэтийн үйлчилгээг ерөнхий боловсролын 17 нэвтрүүлж 100% утасгүй интернэтийн орчин бүрдүүлсэн<br>Мөн "Ачит Ихт" ХХК нь 2025 оны |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хамтын ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд Ерөнхий боловсролын 8, 7-р сургуульд химийн, 4-р сургуульд физикийн иж бүрэн тоног төхөөрөмж бүхий кабинетыг тохижуулсан. |
| **38.** | | | 2.6.1.6. Монгол хэл, бичгийн хичээлийг сурагчдад эзэмшүүлэх арга технологи, орчин бүрдүүлэлтийг сайжруулан, сургалтын чанарыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | Улсын шалгалт, анги дэвших шалгалтын гүйцэтгэл | Хувь | 2023 | 72.4 | 73.6 | - | - | 77.1 | - | 100 | Монгол хэлний судлагдахууны 113 багшийг унших, бичих, илэрхийлэх давуу чадамж, сонирхол, хэрэгцээнд нь тулгуурлан 14 мэргэжлийн бүлэгт хуваарилж, мэргэжлийн хөгжлийн бүлгээр хөгжүүлсэн. Үүний хүрээнд багш нарын дунд 9 удаагийн судалгаат хичээл, 17 удаагийн үзүүлэх хичээл зохион байгуулж харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн. Тайлант хугацаанд Монгол хэл бичиг, элсэлтийн шалгалтын даалгаврын цахим сан бий болгож 12 дугаар ангийн 2 хувилбар бүхий 24 тест, 8 агуулгын хүрээнд 15 удаагийн цахим хичээлийг байршуулж сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Эдгээр ажлын үр дүнд Эдгээр ажлын үр дүнд 2024-2025 оны хичээлийн жилийн Монгол хэлний хичээлийн 9,12 дугаар улсын шалгалтын аймгийн дундаж 80.1%, анги дэвших шалгалтын дундаж 74.2 %-тай байгаа ба улсын болон анги дэвших шалгалтын гүйцэтгэлийн дундаж 77.1 хувь болж өмнөх оноос 4.75 функтээр өссөн байна. Мөн орон нутгийн “Тусгал-1” телевизтэй хамтран аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, үндэсний бичгийн хэрэглээг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 12 дугаар ангийн сурагчдын дунд “Үндэсний бичгийн үсэглэлийн аварга-2025” уралдааныг зохион байгуулж байна. Уралдаанд төрийн болон хувийн хэвшлийн 17 сургуулийн 500 гаруй оролцож байгаа бөгөөд 12 дугаар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | 18-ны өдөр шалгаруулж дууссна. Уралдааныг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. |
| **39.** | | | 2.6.2.1. ХАА-н Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байрыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | 55 | 100 | 6600.0 | УТ | 100 | 6,600.0 | 100 | Улсын төсвийн 10,557.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 оноос барилгын ажил дахин эхэлсэн Политехник коллежийн 320 хүүхдийн суудалтай барилга бүрэн дуусаж улсын комисс хүлээн авсан. |
| **40.** | | 2.6.2.Их дээд сургууль, политехникийн коллежийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ | 2.6.2.2. Орон нутгийн Их дээд сургуультай хамтран ЕБС-ын сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох | Хамрагдсан сурагчдын тоо | Тоо | 2023 | 212 | 400 | 20.0 | ОНТ | 790 | 20.0 | 100 | Тайлант хугацаанд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цуврал сургалтыг ЕБС-иудын 8-12 дугаар ангийн сурагчид болон түүний эцэг, эх асран хамгаалагчдад 72 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 3727 иргэн хамрагдсан байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зарим арга хэмжээний тухай” А/200 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж “ЕБС-иудын 6-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн сайн туршлага солилцох зөвлөгөөн илтгэл хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулж 1, 3, 7, 8, "Ирээдүй одод" сургуулиудын анги удирдсан багш нар болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг хамруулаа. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ЕБС-н ахлах 10, 11 -р ангийн 725 сурагчийг үйлдвэрийн цех нэгжүүдтэй танилцах мэргэжил сурталчлах аялалд, “Эрдэнэт” цогцолбор дээд сургуультай хамтран инженер мэргэжил сонгосон 65 сурагчийг “Ашигт малтмалын баяжуулалтын |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | технологи”, “Цахилгаан системийн автоматжуулалт”, “Мэдээллийн технологи”, “Эрчим хүч, мэдээллийн технологи”, “Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт”, “Уул уурхайн машин тоног төхөөрөмж” зэрэг мэргэжлүүдийн онцлогтой танилцуулах үйл ажиллагаанд тус тус хамруулж ажил мэргэжлийн чиг баримжаа олгосон байна. |
| **41.** | | | 2.6.2.3. Дээд боловсролын байгууллагын багш нарын судалгааны чанарыг дээшлүүлж, дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлсэн багш | Тоо | 2023 | - | 3 | 12.0 | ОНТ | 3 | - | 100 | Тайлант хугацаанд “Эрдэнэт” цогцолбор дээд сургуулийн багш нар нормын дагуу чиглэл тус бүрээр 2 кредит цагийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд тус сургуулиас 2025 оны 12-р сард олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өөрийн хийж буй судалгааны ажлын чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн 3 багшийг 2.0 сая хүртэлх төгрөгийн урамшуулал олгосон. “Эрдэнэт” цогцолбор дээд сургуулийн багш нар захиалгат 10 судалгааны ажил, гадаад улстай хамтарсан 3 судалгааны ажил хийж, эрдэм шинжилгээний 19 өгүүллэг бичиж, 4 ном гарын авлага хэвлүүлж, эрдэм шинжилгээний хуралд 16 багш оролцож судалгааны ажлаа танилцуулсан байна. |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 3: ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.** | | | | | | | | | | | | | | |
| 42. | 3.1.Нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын үйлчилгээг | 3.1.1.Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг | 3.1.1.1. Ач санах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2023 | 80 | 100 | 15.0 | ОНТ | 100 | - | 100 | 2024 онд тус хөтөлбөр 100 хувьтай хэрэгжиж дууссан. Шинээр Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43. | сайжруулна | бүрдүүлнэ | 3.1.1.2. Анхдагч хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2023 | 80 | 100 | 15.0 | ОНТ | 100 | - | 100 | 2024 онд тус хөтөлбөр 100 хувьтай хэрэгжиж дууссан. Шинээр Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. |
| **44.** | | 3.1.2.Зорилтот бүлгийн хүн амын амьжиргааны баталгааг хангана. | 3.1.2.1. Нийгмийн халамжийн багц хуулийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд | Тоо | 2023 | 42000 | 42000 | 272.1 | УТ, ОНТ | 42000 | 26,200.0 | 100 | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг оролцуулалгүйгээр 42.0 мянган иргэн хамрагдаж 26.2 тэрбум төгрөг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. |
| **45.** | | 3.1.3.Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулна | 3.1.3.1. Нийгмийн даатгалын ач холбогдлын талаар иргэд олон нийтэд сургалт зохион байгуулж, хамрагдалтын нэмэгдүүлэх | Сургалт, сурталчилгаанд хамрагдагсдын тоо болон зохион байгуулсан сургалтын тоо, чанар | Тоо | 2023 | 2500 | 5000 | 20.0 | ОНТ | 4764<br>71 | - | 90.6 | Ажил олгогч, даатгуулагч, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 71 удаагийн сургалтад 3431 иргэд, даатгуулагчийг хамруулсан. Мөн явуулын үйлчилгээгээр 20 чиглэлд 2 удаа малчдаар явуулын үйлчилгээ хүргэн ажиллаж 678 өрхийн 789 малчин иргэнд мэдээлэл зөвлөгөө хүргэж, 15 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт 544 иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэж ажилласан. |
| **46.** | | | 3.1.3.2. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт | Хувь | 2023 | 100 | 100 | - | - | 83.5 | - | 83.5 | 2025 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлогод 177.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн Сангийн орлогын төлөвлөгөө 83.5 хувьтай биелсэн. |
| **47.** | | | 3.1.3.3. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх | Сайн дурын даатгалд даатгуулагчид | Тоо | 2023 | 5055 | 5060 | - | - | 5065 | - | 100 | 2025 онд энгийн сайн дурын даатгалд 939 иргэнийг, малчин даатгуулагчаар 68 иргэнийг, 0-3 настай хүүхдээ асарч байгаа 90 эхийг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 33 эцэг, эхийг тус тус шинээр хамруулснаар сайн дураар нийгмийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо 5065 байна.<br>Үүнээс энгийн сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо 3846 төрөөс сайн дурын даатгалын тодорхой хувийг хариуцан төлж байгаа малчин даатгуулагч 326, 0-3 настай хүүхдээ асарч байгаа эх 739, хөгжлийн бэрхшээлтэй |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хүүхдээ асарч байгаа эцэг эх 154 байна. |
| | | | | Албан журмын даатгалд даатгуулагчид | Тоо | 2023 | 29600 | 29650 | - | - | 29621 | - | 58 | 2025 оны жилийн эцсийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж тайлан ирүүлсэн 1494 аж ахуй нэгж байгууллагын 29621 ажилтан, албан хаагч албан журмын даатгуулагчийн цалин хөлсний сан түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэн ажиллаж НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллаж орлогын төлөвлөгөөг биелүүлсэн. |
| 48. | 3.2. Хүүхэд, гэр бүл хамгааллын үйлчилгээг сайжруулна | 3.2.1. Гэр бүлийн хөгжлийг дэмжсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 3.2.1.1. “Бүх хайраа гэр бүлдээ” өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан иргэд | Тоо | 2023 | 8000 | Өмнөх оноос бууруулахгүй | 15.0 | ОНТ | 8200 | 23.6 | 100 | Орхон аймгийн Засаг даргын А/363 захирамжийн дагуу Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Хүүхэд–Хайр–Ирээдүй” уриан дор “Бүх хайраа гэр бүлдээ” сарын аяныг аймгийн хэмжээнд 20 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 7 арга хэмжээг зохион байгуулж, нийт 8200 гаруй иргэнийг хамрууллаа. Үүнд:<br>“Бүх хайраа гэр бүлдээ” өдөрлөгийг Баян-Өндөр болон Жаргалант суманд зохион байгуулж 4500 гаруй иргэд оролцсон.<br>“Өглөөний эвент” сургалтыг 12 удаа зохион байгуулж, 20 төрийн болон төрийн бус байгууллагын 480 гаруй ажилтан гэр бүлээрээ оролцсон, “Бүх хайраа гэр бүлдээ сэтгэл зүйн өдөрлөг” зохион байгуулагдаж, 150 хүн сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтад хамрагдлаа. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Гэр бүлийн ордонтой хамтран 8 залуу гэр бүлийн хурмын ёслолын арга хэмжээг 50% хөнгөлж зохион байгуулсан.<br>Насан туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг зохион байгуулж 330 гаруй иргэдийг хамруулсан.<br>Гэр бүлтэйгээ цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх гэр бүлийн цаг тооны бичиг, аз жаргалын хуримтлалын хайрцаг, гэр бүлийн тухай хуулийн эмхэтгэл зэрэг гарын авлага тараах материалыг 2700 гаруй иргэн тархаасан.<br>Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах чиглэлээр Орхон аймгийн нийт гэр бүлийн 1.2 хувийг төлөөлөх 361 өрхийн дунд гэр бүлийн суурь судалгааг явуулж, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээний хэрэгцээг үнэлж, салбар дундын оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Бүх хайраа гэр бүлдээ” зорилтот төслийг боловсруулсан бөгөөд уг төслийг 2026 онд хэрэгжүүлэхээр Аймгийн Засаг даргаар батлуулсан.<br>Тайлант онд гэр бүлийн чиглэлээр 62 удаагийн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, 15000 иргэн, 9821 өрх хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад сургалтад хамрагдсан иргэдийн тоо 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. |
| **49.** | | | 3.2.1.2. Эвлэрүүлэн зуучлах сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх “Гэр“ төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Ажилласан гэр бүл | Тоо | 2023 | 132 | Өмнөх оноос өссөн байна | 40.0 | ОНТ | 163 | 30.0 | 100 | Эвлэрүүлэн зуучлах сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх “Гэр“ төслийг 2025 оны 02 дугаар сарын 20 ны өдрийн А/154 тоот захирамжаар төлөвлөгөөг батлуулж 7 арга хэмжээг төлөвлөн 30.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | ШТГ-ын эвлэрүүлэн зуучлахад өргөдөл өгсөн гэр бүл болон Шүүхийн анхан шатны хуралд оролцож эвлэрлийн хугацаа өгөгдсөн 163 гэр бүлтэй ажиллаж, ганцаарчилсан болон хосын зөвлөгөөг 650 иргэнд өгч ажилласан. Үүнээс 2025.12 сарын байдлаар 52 гэр бүл эвлэрсэн тоон үзүүлэлттэй байна. Гэр бүлийн зөвлөгөөг эвлэрсний дараах хосын харилцааг сайжруулахад болон салалтын дараах сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах, гэсэн 2 төрлөөр эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, хосын зөрчилдөөнийг арилгахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан байна. 2025 онд гэр бүл цуцлуулахаар өргөдөл өгсөн иргэдээс гэр бүл салалтын суурь шалтгаан нөхцөлийг тодоруулах судалгаанд нийт 81 иргэн хамрагдсан. |
| **50.** | | 3.2.2. Хамтарсан баг болон эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулна | 3.2.1.3. Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх. | Шийдвэрлэсэн кейс | Тоо | 2023 | 48 | 50 | 40.0 | ОНТ | 236 | 102.9 | 100 | Улсын хэмжээнд 2025 оны 02-р сарын 01-ны өдрөөс 833 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж эхлэхтэй холбоотойгоор 2 сум, 26 багийн хэмжээнд 24 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан томилон ажиллуулж байна. Тайлант онд хүүхдийн тусламжийн 108 утас, 102 утасны дуудлагын гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагын дагуу 246 кейс нээн үйлчилгээг үзүүлэн ажиллаж, 236 кейсийг шийдвэрлэж, 10 кейс дээр ажиллаж байна. |
| **51.** | | | 3.2.1.4. Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хандлагыг төлөвшүүлэх | Сургалт, уулзалтад хамруулсан эцэг эх | Тоо | 2023 | 12681 | 15000 | 60.0 | УТ | 28422 | 33.7 | 100 | Төрийн болон хувийн хэвшлийн 121 байгууллага эцэг эхийн зөвлөлтэй бөгөөд 18 байгууллага хүүхдийн өрөөг бий болгож, 112 байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад хүүхэд хамгааллын бодлогыг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хэрэгжүүлэн ажиллаж байгаа байгууллагын тоо 17-оор буюу 58.8 хувиар нэмэгдсэн байна.<br>Мөн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд төрийн байгууллага, аж ахуй нэгж байгууллага гэсэн 2 чиглэлээр 60 байгууллагыг хамруулан зөвлөн туслах арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулсан.<br>Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 12 удаагийн сургалтад 192 иргэн, эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг хамруулсан.<br>Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга зүй сургалтад 78 байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг хамруулсан.<br>Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхдийг болзошгүй эрсдэл болон ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөмжийг давхардсан тоогоор 28422 эцэг эхчүүдэд хүргэсэн. |
| **52.** | | 3.2.3. Бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөнө | 3.2.3.1. Өсвөр үеийн охид, хөвгүүдэд бэлгийн боловсролын сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | Сургалтанд хамрагдсан өсвөр үе залуучууд | Тоо | 2023 | 4500 | 5000 | 7.0 | ОНТ | 6409 | 5.0 | 100 | Өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэх" сургалтыг зохион байгуулж, Ерөнхий боловсролын 19 сургуулийн 50 хүүхдийг үе тэнгийн зөвлөгчөөр бэлтгэж 5 цогц арга хэмжээнд 6409 иргэнийг хамруулсан. Тухайлбал:<br>- "Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сургалт, хэлэлцүүлгийг ЕБС-ийн 19 сургуулийн дунд, ахлах ангийн 101 бүлгийн 2702 хүүхдийг сурагчдад зохион байгуулж, 552 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан. Мөн эдгээр хүүхдүүдэд зохистой |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, бэлгийн бойжилт, хувийн ариун цэвэр, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө бүхий 18 төрлийн 3155 гарын авлагыг түгээж 13 төрлийн постерийг давхардсан тоогоор 68219 иргэнд, 4 төрлийн видео шторкийг давхардсан тоогоор 23840 иргэдэд цахим хуудсаар түгээсэн байна. |
| **53.** | | | 3.2.3.2. Жендерийн хэвшмэл ойлголтыг иргэд, бүх нийтэд сурталчлан таниулах олон талт нөлөөллийн ажлыг зохион байгуулах | Хамтран ажилласан төрийн бус байгууллага | Тоо | 2023 | 3 | 4 | 38.0 | ОНТ | 4 | 23.0 | 100 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар 2024 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж, аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаар тайланг хэлэлцүүлж, Жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн. 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг байгууллагуудаас авч, нэгтгэн төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлуулсан. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан ажлын байран дахь жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 12 удирдах ажилтныг онлайнаар хамруулж тэдний ажлын байран дахь жендерийн тухай мэдлэг ойлголт сайжирсан. 4 ТББ-тай гэрээ байгуулан өсвөр үе хүүхэд багачуудад хөгжил хамгааллын өдрийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр хамтран ажиллаж 13.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Иргэд олон нийтэд жендерийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр "Жендерийн ерөнхий ойлголт", "Жендерт суурилсан хүчирхийлэл"-ийн тухай сургалтыг 5 байгууллагын 152 албан хаагч хамрагдаж, тэдний жендерийн тухай мэдлэг ойлголт нэмэгдсэн. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан ажлын байран дахь жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 12 удирдах ажилтныг онлайнаар хамруулж тэдний ажлын байран дахь жендерийн тухай мэдлэг ойлголт сайжирсан. Орон нутгийн жендерийн сургагч багштай хамтран эрсдэлийн программд бүртгэлтэй 20 өрхийн 43 эрэгтэйтэй амьдралын зерэг дадал, эрүүл хооллолт, амьдрах ухааны сургалтыг 6 удаа үе шаттай зохион байгуулснаар тэд эрүүл хооллолт, зерэг дадал зуршлын талаар ойлголт нэмэгдсэн. Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяны хүрээнд сургалт, цахим хичээл, контент, жендерийн ойлголтыг олгох тест зэрэг арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3983 гаруй иргэдийг хамруулж, 10.0 сая төгрөг зарцуулсан. |
| 54. | 3.3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ | 3.3.1. Иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулж тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 3.3.1.1. Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг үзүүлэх | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэд | Тоо | 2023 | 1000 | 600 | 7.4 | УТ | 1414 | 7.7 | 100 | Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээнд 739 иргэн, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг 438 иргэн, ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө мэдээллийн ганцаарчилсан үйлчилгээнд 150 иргэн, бүлгийн зөвлөгөө мэдээлэл 525 нийт 1414 иргэн хамрагдаж 7.7 сая төгрөг зарцуулсан. Ejob үйлчилгээний төвтэй хамтран ажилгүй, ажил идэвхтэй хайж байгаа иргэдэд зориулж Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг Баян-өндөр сумын 8 багийн 7 бүлгийн 128 иргэнд зохион байгуулсан. |
| 55. | | | 3.3.1.2. Ажил хайгч иргэдийг тохирсон ажлын байранд зуучлах, бүртгэх мэргэшсэн үйлчилгээг хэрэгжүүлэх | Ажлын байранд зуучлагдсан иргэд | Тоо | 2023 | 1100 | 1000 | 4.9 | УТ | 1127 | - | 100 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | (хөтөлбөр)-ны хүрээнд JOB CENTER төвийг "Монголын хүний нөөцийн менежментийн холбоо" НҮТББ-ын дэргэдэх Хөдөлмөрийн хувийн биржтэй хамтарч 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн ажиллуулж эхэлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан Ejob платформд 615 иргэнийг ажил хайгчаар, 340 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 1878 ажлын байрны захиалга бүртгэсэн. Ажилд зуучлал 1127 иргэн, шинэ ажлын байранд 1052 иргэнийг бүртгэсэн. |
| 56. | | | 3.3.1.3. Тогтвортой ажлын байрыг бий болгож, шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж байгууллагад ажил олгогчийн урамшуулал олгох | Ажил олгогчийн урамшуулалд хамрагдах аж ахуйн нэгж байгууллага | Тоо | 2023 | 15 | 10 | 27.0 | УТ | 0 | - | 0 | Тогтвортой ажлын байрыг бий болгож, шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулалд хамрагдах боломжоор ажил олгогчдыг мэдээллээр хангах, идэвхжүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудас болон нээлттэй хаалганы өдөрлөг, ажил олгогчийн уулзалт зөвлөгөөнд танилцуулж урамшууллын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэж ажилласан. 2025 онд гэрээ байгуулахаар 4 аж ахуйн нэгж 6 ажлын байранд хүсэлт гаргасан боловч гэрээнд тавигдах шаардлага хангаагүй тул урамшуулал олгогдоогүй болно. |
| 57. | 3.4. Ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ | 3.4.1. Хоршоо эрхлэгчдийг бодлогоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 3.4.1.1. Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, зээлийн дэмжлэгт хамруулах | Дэмжсэн хоршоодын тоо, Кластер үйлдвэрлэл, үйлчилгээ | Тоо | 2023 | - | хоршоо 25, кластер үйлдвэрлэл 1-ээс доошгүй | 950.0 | УТ | 31 хоршоог дэмжиж, 7 хоршоонд зээл олгосон | 529.0 УТ 422.7 ОНТ | 100 | Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хууль, "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Булган аймагт зохион байгуулагдсан хойд бүсийн зөвлөгөөнд малчдын 20 төлөөлөл оролцож мэдээлэл авсан. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд шинээр 1330 гишүүнтэй 115 хоршоо шинээр байгуулагдсан ба 47 хоршооны 174 малчин 6.4 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан. Үүнээс 2025 онд 203 гишүүнтэй 23 хоршоо шинээр байгуулагдаж, 7 хоршоо 529.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. Хоршоо хөгжүүлэх сангаас 2025 онд 5 хоршоо 422.7 сая төгрөгийн зээлд хамрагдсан. Эрчимжсэн мал аж ахуйн фермерийн зориулалтаар 3 хоршоонд 11.4 га газар эзэмшүүлсэн. Мөн хоршоодыг чадавхжуулах, мэдлэг олгох зорилгоор 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 256 хүн хамруулсан бол 2 удаагийн туршлага судлах арга хэмжээ зохион байгуулж 16 хоршооны төлөөллийг оролцуулсан. |
| 58. | | | 3.4.1.2. “Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ыг орон нутагт хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2023 | 100 | 100 | 20.0 | ОНТ | 100 | 8.0 | 100 | Аймгийн Засаг даргын 2025 оны "Хоршооны салбарын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/339 дүгээр захирамжаар батлагдсан төлөвлөгөөнд 7 зорилт 22 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж 8.0 сая төгрөг зарцуулан төлөвлөгөө 100 хувьтай хэрэгжсэн. Үүнд хоршоо эрхлэгчдийг сургалтад хамруулж чадавхжуулах, үзэсгэлэн худалдаанд оролцуулж борлуулалтыг дэмжих, шинэ технологи, инновац нэвтрүүлэх зорилгоор туршлага судлуулах, хоршоодын сайн туршлагыг олон нийтэд хүргэх, сурталчлах, мэдлэг мэдээлэл авах, харилцан санал солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Улсын зөвлөгөөнд оролцуулах, зээлд хамрагдсан хоршоодын үйл ажиллагаанд хяналт хийх, зээлийн зарцуулалтын үр дүнг тооцох зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан. Мөн хоршоодыг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | чадавхжуулах, мэдлэг олгох зорилгоор 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 256 хүн хамруулсан бол 2 удаагийн туршлага судлах арга хэмжээ зохион байгуулж 16 хоршооны төлөөллийг оролцуулсан. |
| 59. | | | 3.4.1.3. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг орон нутагт хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2023 | 100 | 100 | 20.0 | ОНТ | 100 | 8.0 | 100 | Аймгийн Засаг даргын 2025 оны А/452 дугаар захирамжаар "Ахуйн үйлчилгээний салбарын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд 4 зорилт, 11 арга хэмжээ тусган хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Монголын Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран "Монголын Үсчин Гоо Сайхны Хөгжил-2030" чуулган зохион байгуулж, 14 аймаг орон нутгийн холбоод, 10 гаруй байгууллагууд, 250 гаруй мэргэжилтэн нар идэвх санаачилгатай оролцсон.<br>Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх 2 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 64 хүн хамрагдсан. "Бикини ваксны-ONE TOUCH" сургалт, Дэлхийн аварга, Алтан цомын эзэн, Дэлхийн дасгалжуулагч МУ-ын мастер А.Магнай амжилтад хүрсэн туршлагаасаа хуваалцаж зөвлөгөө өгсөн.<br>Жаргалант сумын иргэдэд зах зээлийн үнээс хямд, нэг цэгээс хүрч үйлчлэх, үйлчилгээ эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Явуулын ахуйн үйлчилгээ" зохион байгуулж давхардсан тоогоор 100 гаруй хүнд үйлчилгээ үзүүлж 1,8 сая төгрөгийн орлоготой ажилласан.<br>Монголын Барбер Холбоо, Үсчин, гоо засалчдын холбоотой хамтран үсний тайралт, хэв маяг оруулалт, үс засалтыг сурталчлан таниулах, харилцан суралцаж, хамтдаа хөгжих зорилгоор "Mongolian old school barber battle 2025" аймгийн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Queen barber shop салонд зохион байгуулж 14 оролцогч 6 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан. Стандартын шаардлага хангасан үс засах үйлчилгээ, алжаал тайлах бариа заслын үйлчилгээ эрхлэх 14 аж ахуйн нэгжид 1-2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгосон. |
| 60. | | 3.4.2. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөрт хамрагдах, санхүүгийн зах зээлд гарах нөхцөлийг бүрдүүлнэ. | 3.4.2.1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, үр дүнд хяналт үнэлгээ хийх | Олгосон зээлийн хэмжээ | Тэрбум төгрөг | 2023 | 1.0 | 1.4 | 1400.0 | УТ | 3.6 | 3,639.7 | 100 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын хамтарсан гэрээгээр 2025 онд орон нутгийн төсвөөс 300.0 сая төгрөгийг ЖДҮХС-нд байршуулсан. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилт буюу нийт 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэртэй зээл зарлаж 10 төсөлд 1.3 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүний үр дүнд 18 ажлын байр шинээр бий болж, 29 ажлын байр хадгалагдсан байна. Атар-4 тариалангийн тогтвортой аяны хүрээнд 5 аж ахуйн нэгж, 7 иргэнд 1.2 тэрбум төгрөг, Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд 1 аж ахуйн нэгж 188.0 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 5 хоршоонд 422.7 сая төгрөг, Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 6 хоршооны 16 малчин өрхөд 529.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. |
| | | | | ЖДҮХС-аас хөнгөлөлттэй зээл авсан нийт аж ахуйн нэгжүүдэд хийсэн хяналт шинжилгээ | Хувь | 2023 | 100 | 100 | 5.0 | ОНТ | 100 | 3.0 | 100 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2025 онд нийт 38 төсөлд 4.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Үүний үр дүнд 105 ажлын байр шинээр нэмэгдэж 168 ажлын байр хадгалагдсан.<br>Зээлийн эргэн төлөлт, төсөл хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийхийн зэрэгцээ сар бүрийн 19, 20- |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | нд зээлдэгч тус бүртэй утсаар холбогдож төлөлт болон зээлийн ямар төлөвт байгааг сануулах, зээлийн санхүүжилтийг үр дүнтэй зарцуулж, үйлдвэрийн үйл ажиллагаандаа ахиц дэвшил гарган амжилттай ажиллаж байгаа үйлдвэрийг орон нутгийн телевиз, сайтуудтай хамтран сурталчлан ажиллалаа. Нийт 38 төслөөс зээлийн үлдэгдэлтэй 27 аж ахуйн нэгжид хяналт хийхээр төлөвлөж, 100 хувь хэрэгжүүлсэн. |
| 61. | | | 3.4.2.2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулан сурталчлах, борлуулалтыг дэмжих үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | Зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа | Тоо | 2023 | 2 | 1-ээс дээш | 20.0 | ОНТ | 10 | 7.5 | 100 | Тайлант хугацаанд 10 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 280 иргэн аж ахуйн нэгж бизнес эрхлэгчдийн оролцуулан 902.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үүнд:<br>Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны хүрээнд Булган аймгийн төв талбайд “Түншлэл-Хамтын ажиллагаа” үзэсгэлэн зохион байгуулагдаж Орхон аймгаас 25 үйлдвэрлэгчийг оролцуулсан.<br>“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга” хэлэлцүүлэгт хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 56 иргэн, аж ахуйн нэгж оролцон санал өгч үзэсгэлэн худалдаанд оролцсон.<br>"Дэлхийн Жижиг дунд үйлдвэрийн өдөр -2025" арга хэмжээ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж орон нутгийн 7 аж ахуйн нэгж 280 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 35.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Нүүдэлчин" фестивальд Аранжин угалз брэнд, Жигүүр брэнд, Төгс брэнд, Сампин брэнд, Зэс брэнд, Өндөрлөг брэнд, Ширмэг зэрэг 15 брэнд бүтээгдэхүүн амжилттай оролцож |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | 45.0 сая төгрөгийн борлуулалттай ажилласан.<br>“Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2025” нэгдсэн арга хэмжээнд орон нутгаас хүнс, хөнгөн, газар тариалангийн чиглэлийн 15 иргэн, аж ахуйн нэгж оролцож 102.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>“Зэс фестиваль-2025” арга хэмжээнд зэс бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болон худалдаалдаг 18 иргэн, аж ахуйн нэгж оролцож 300,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>“MiningWeek & MinePro 2025” арга хэмжээнд Бурамт баялаг хоршоо эко саван, Ариун-зөгийн бал, Ачит андага-артишокын ундаа, Баяр мөнх наран-эрүүл мэндийн цай зэрэг бүтээгдэхүүнээр оролцож уул уурхайн компаниудад танилцуулан хамтран ажиллах талаар санал солилцож холбоо тогтоосон.<br>Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор бүтээгдэхүүний цахим каталог гаргаж, 80 аж ахуйн нэгжийн 500 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг холбогдох мэдээллийн хамт байршуулан сурталчилж байна. |
| 62. | | 3.4.3. Бизнес эрхлэгчидийг чадавхижуулж, гарааны бизнесийг дэмжиннэ | 3.4.3.1. Инновацын сургалт зохион байгуулах | Хамрагдсан бизнес эрхлэгч | Тоо | 2023 | 75 | 75 | 15.0 | ОНТ | 150 | - | 100 | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас MS-development ХХК-ын сургалтын төвтэй хамтран “Бизнесээ эхэл-Бизнесээ эхлүүл” , “Төсөл хэрхэн бичих вэ” сургалтад 130 иргэнийг 3 өдрийн турш хамруулсан.<br>“Egan brend consulting” ХХК-тай хамтран орон нутгийн түүхий эд, нөөц баялгийг ашиглан брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, аймгийн хэмжээнд Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | үзүүлэх, шинэ зах зээл, шинэ түншлэл бүхий олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, нэр төрлийг олшруулах, өрсөлдөх чадварыг бий болгох, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилгоор “Брэндээ бүтээ, хамгаал, арчил, үнэ цэнийг өсгө” сэдэвт сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. Сургалтад 20 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож, 10 аж ахуйн нэгжид бүлгийн болон ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ үзүүлж гарын авлага материалаар ханган ажилласан |
| 63. | | | 3.4.3.2. Инновац, технологийн судалгаа хийх, дамжуулах | Дамжуулсан технологи | Тоо | 2023 | 2 | 2 | 15.0 | ОНТ | 2 | - | 100 | 2025 онд нэхмэл болон цаасны хаягдал ашиглан барилгын дүүргэгч материал үйлдвэрлэх технологийн туршилт, судалгаа хийж бизнес эрхлэгчид дамжуулах ажлыг зохион байгуулсан. |
| 64. | | | 3.4.3.3. Бизнес ширээгээр иргэдэд нэг цэгийн мэдээлэл өгөх | Мэдээлэл, зөвлөмж өгсөн иргэд | Тоо | 2023 | 250 | 250 | 20.0 | ОНТ | 255 | - | 100 | Давхардсан тоогоор 255 иргэнд кластер үйлдвэрлэл, бизнес эрхлэх чиглэлээр сургалт явуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслийн тоног төхөөрөмж гэрээгээр ашиглуулах, хяналт тавих ажил хийгдсэн. |
| 65. | | | 3.4.3.4. Гарааны бизнесийн арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2023 | 2 | 2 | 50.0 | ОНТ | 2 | - | 100 | Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох (start up) арга хэмжээний хүрээнд шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг гарааны бизнес эрхлэгч залуу болон залуучуудын багийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж старт залуучуудын бүлэгт 6 төсөлд 70.0 сая төгрөгийн дэмжлэгийг буцалтгүйгээр олгосон. Мөг уг арга хэмжээг бүсийн хэмжээнд "Бест метод" ТББ-тай хамтран зохион байгуулж Хөвсгөл , Булган, Орхон аймгийн 111 залуучуудыг бүртгэж, 3 өдрийн сургалтыг зохион байгуулж 1-р шатны сонгон шалгаруулалтад |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Булган аймаг 1, Хөвсгөл аймаг 2, Орхон аймаг 4 нийт 7 баг шалгарч 5 долоо хоногийн хугацаатай хурдасгуур хөтөлбөрт хамрагдаж, эцсийн сонгон шалгаруулалтаар 3 багт 52.0 сая төгрөгийн 36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй 50 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгосон. |
| 66. | | | 3.4.3.5. Гарааны компани бүртгэх, зөвлөх | Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн компани | Тоо | 2023 | 5 | 5 | 5.0 | ОНТ | 9 | - | 100 | Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох аймгийн болон бүсийн (start up) арга хэмжээнээс шалгарсан 9 төсөлд ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. |
| 67. | | | 3.5.1.1. Сорилын жишиг төв болгон ашиглах спортын А зааланд засварын ажлыг хийх. | Сорилын төвийн өргөтгөл, засварын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | - | 100 | 950.0 | ОНТ | - | - | 100 | Биеийн тамир, спортын газар үйл ажиллагааны 3.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сорил, чийрэгжүүлэлтийн төвийг байгуулж, засвар үйлчилгээ хийж ашиглалтад оруулан 410 ажилтан, албан хаагч, өсвөрийн тамирчдаас сорил авч нийт 6800 иргэнийг сорилд хамруулсан. |
| 68. | 3.5. Идэвхтэй хөдөлгөөн хийдэг иргэдийг нэмэгдүүлнэ | 3.5.1. Нийтийн биеийн тамирын ач холбогдлын талаар зөв мэдлэгтэй иргэдийг нэмэгдүүлж, орчин нөхцлийг сайжруулна | 3.5.1.2. Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг иргэд, ААНБ-уудын дунд өрнүүлэх | Дасгал хөдөлгөөнд хамрагдсан иргэд /давхардсан тоогоор / | Тоо | 2023 | 24400 | 25000 | 25.0 | ОНТ | 25414 | 23.4 | 100 | “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд биеийн тамир, чийрэгжүүлэлт, спортын өдөрлөг, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 33 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 25,414 иргэнийг хамруулсан. Арга хэмжээнд орон нутгийн төсвийн 23,4 сая төгрөгийг зарцуулсан. |
| 69. | | | 3.5.1.3. Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлэн “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн” болон бусад газар мөсөн талбай байгуулж хичээллэх нөхцлийг бүрдүүлэх | Мөсөн талбайн тоо | Тоо | 2023 | 4 | 6 | 30.0 | ОНТ Хувийн хэвшил | 6 | - | 100 | Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж, цанын зам 3, мөсөн талбай 3, нийт 6 зам талбай байгуулж, тэмцээн уралдаан зохион байгуулах, хүүхэд залуусыг өвлийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа.Үүнд:<br>-Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд мөсөн талбай,<br>-"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н Сархиа баазад цанын зам 3,<br>-Орос 19-р сургуулийн хоккейн талбай, |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | -ерөнхий боловсролын 15 сургуулийн гадна мөсөн талбайг тус тус байгуулж, улсын аварга шалгаруулах /мөсний шагай, гүйлтийн цана, уулын цана, сноубоард, цасны гуталтай гүйлт, авто дрифт/ 6 тэмцээнд 579 тамирчин, аймгийн аварга шалгаруулах болон олон хотын аварга шалгаруулах тэмцээнийг 4 удаа зохион байгуулж, 270 тамирчдыг хамруулсан.<br>-Мөсөн талбай, цана, чаргын зам талбайд 3 иргэн, аж ахуйн нэгж спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээг 4200 гаруй иргэнд үзүүлсэн. |
| 70. | | | 3.5.1.4. Спортын цогцолбор барих зураг төсөв боловсруулах | Зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | - | 100 | - | - | 100 | - | 100 | Аймгийн хэмжээнд спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр "Эрдэнэт спортын цогцолбор"-ын зураг, төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр "Зэд прожект" ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн. |
| 110. | 4.6. Гадаад, дотоодын жуулчдыг татаж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ. | 4.6.1. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангана | 4.6.1.1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх эвент арга хэмжээ зохион байгуулах | Эвент арга хэмжээ | Тоо | 2023 | 2 | 2 | 50.0 | ОНТ | 2 | 250.0 | 100 | Дотоод гадаадын жуулчдыг татах зорилгоор Эрдэнэт хотод 2 дахь удаа А.Амарын талбайд Монголын дрифтийн тамирчид энэ жилийн цуврал тэмцээний 5 раундыг амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээнд мэргэжлийн ангиллын 31 тамирчин, сонирхогчдын ангиллын 47 тамирчин, нийт 78 тамирчин оролцсон бөгөөд тэмцээнийг зорин ирэх тамирчид, үзэгчдийн тоо нэмэгдсээр байна.<br>Орон нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын эвентийг хөгжүүлэхээр “Зэс” фестиваль арга хэмжээг уул уурхайн 5 аж ахуйн нэгжтэй хамтран 3 дахь жилдээ зохион байгуулж, зэсийн баяжмал үйлдвэрлэгч уул уурхайн үйлдвэрүүдийг сурталчлах, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний худалдаа, зэс, зэсэн эдлэлийн гэр музейн үзэсгэлэн, байгальд ээлтэй цахилгаан машины үзэсгэлэнд 18 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцсон. “Зэс фестиваль”-ийн хүрээнд аймгийн Музейн үзмэрт хадгалагдаж буй зэсэн урлал, эд өлгийн зүйлсийн “Гэр” музей, “Монгол зэс” зэсээр урласан бүтээлийн үзэсгэлэн худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн худалдаа үйлчилгээ, гадаа талбайн кино үзвэр, 13 удаагийн урлаг соёлын уралдаан, тэмцээн, шоу арга хэмжээнүүдэд 12000 иргэд хамрагдсан. Үзэсгэлэн худалдаанд нийт 200 гаруй нэр төрлийн зэсэн бүтээгдэхүүн дэлгэгдэж, 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулж, 300.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 111. | | | 4.6.1.2. Аймгийн аялал жуулчлалын веб сайтыг ашиглалтад оруулах. | Мэдээлэл авсан иргэд | Тоо | 2023 | - | 2000 | 10.0 | ОНТ | - | - | 0 | Булган аймагт зохион байгуулагдсан Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан болон Орхон аймаг, Эрдэнэт хотод зохион байгуулсан "Хойд бүс-Эрдэнэт 2025" эдийн засгийн форумын үеэр аялал жуулчлалын байгууллагын танилцуулга, мэдээлэл, брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг Орхон аймгийн зочлох үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулж танилцуулга мэдээлэл, гарын авлага материалыг 600 гаруй иргэнд хүргэж ажиллалаа. Мөн "Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо"-той Орхон аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа жуулчны үйлчилгээний байгууллага жуулчны бааз, зочид буудал, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийн ангилал зэрэглэлийг тогтоох, аялал жуулчлалын судалгаа, дата мэдээллийг хамтран гаргах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн сүлжээний сувгаар сурталчлах чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын пэйж хуудсаар дамжуулан аялал жуулчлалын цаг үеийн мэдээ, мэдээлэл, зохион байгуулсан ажлыг нийт 5000 гаруй хүнд хүргэн ажиллалаа. |
| 112. | | | 4.6.1.3. Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох | Сурталчилсан бүтээгдэхүүн | Тоо | 2023 | 5 | 5 | 15.0 | ОНТ | 9 | 8.0 | 100 | ITM MONGOLIA-2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн "Тогтвортой аялал жуулчлал – Төв ази" уриа дор 26 дахь жилдээ 10 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулагдсан. Тус үзэсгэлэнд 21 аймаг, төр хувийн хэвшил, бизнес эрхлэгч, жижиг дунд |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | үйлдвэрлэгч, зочлох, угтах, үдэх зэрэг аялал жуулчлалын бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэгчид оролцсон. Орхон аймгаас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолбор, “Сэлэнгэ амралт” аялал жуулчлалын цогцолбор, "Зэс-Агула" амралтын газар, "Танан" дэн буудал, "Эрхт 888" зочид буудал, "Эрдэнэт ИНН" зочид буудал, “Хуримт” зочид буудал, “Түмэн сүлжээ” ХХК-ны ноос ноолууран эдлэл, “Ширмэг цүнх” ХХК-ны Арьс ширэн эдлэлийн хамт олон оролцож өөрсдийн үйлчилгээ, үйл ажиллагаа, бүтээл, орон нутгаа сурталчилж 3.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. |
| 113. | | 4.6.2. Гадаад улс орнуудтай хийх хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлнэ. | | 4.6.2.1. Эдийн засаг соёлын өдрүүд арга хэмжээг ах дүүс хотуудтай харилцан зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт | Хувь | 2023 | - | 100 | 41.8 | ОНТ | 100 | 41.8 | 100 | 2025 оны 9-р сарын 22-25-ны өдрүүдэд “Улан-Үдэ хотын эдийн засаг, соёлын өдрүүд” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Улан-Үүд хотын захиргааны 15, салбар бүрийн бизнесийн 25 компанийн төлөөлөл, урлаг соёлын 80, нийт 120 хүний бүрэлдэхүүнтэй хүрэлцэн ирж, 50 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулсан бизнес уулзалт болон Соёл урлагийн цогцолборт Улаан Үүд хотын уран бүтээлчдийн 2 удаагийн тоглолтыг зохион байгуулж, Эрдэнэт хотын иргэдэд толилуулсан. |
| 114. | | | 4.6.2.2. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2023 | 4 | 4 | 70.0 | ОНТ | 6 | 70.0 | 100 | Хамтын ажиллагаат улс орнуудын Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд тэргүүтэй төлөөлөгчидтэй 4 удаагийн албан ёсны уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар эрүүл мэнд, боловсролын салбарын хүрээнд харилцан санал солилцсон. Европын холбоо, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн нээлтийн арга хэмжээнд Монгол дахь Суурин төлөөлөгч Ханнес Такач тэргүүтэй |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | төлөөлөгчид оролцсон. Харилцаа хамтын ажиллагаат хот болох БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хоттой санамж бичгийн хүрээнд Бугат хотын Засаг захиргааны байгууллага болон боловсролын газартай аймгийн Боловсролын газар, Политехник коллеж, 14-р сургуулийн удирдлага болон багш, сурагчид хамтран "Цахим уулзалт" зохион байгуулсан. Мөн "Хойд бүс-Эрдэнэт 2025" 5 дахь удаагийн эдийн засгийн форумыг зохион байгуулсан. Форумд Солонгос улсын Дэгү Хани их сургууль, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөлөгч, Чек улсын элчин сайд нар урилгаар оролцон боловсон хүчин бэлтгэх агаарын бохирдол, цэвэр усны хангамжийг сайжруулах, нийгмийн салбарын байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлж гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ-ЭРДЭНЭТ ХҮЧ БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 5: ЦАХИМ СИСТЕМД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ӨРГӨЖҮҮЛЖ, БЭХЖҮҮЛНЭ** | | | | | | | | | | | | |
| 115. | 5.1. Төрийн анхан шатны нэгжийн чанар, хүртээмжийг сайжруулж төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэнэ | 5.1.1. Багийн үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, баг иргэн хоорондын харилцааг идэвхжүүлнэ | 5.1.1.1. Багийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2023 | 70 | 100 | 250.0 | ОНТ | 100 | 926.5 | 100 | Багийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2025 онд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлсэн. Үүнд:<br>Багуудын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор багийн байр болон иргэний танхимын урсгал засвар, тохижилтод сумын төсвөөс 303.0 сая төгрөг, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангахад 185.0 сая төгрөг зарцуулсан. Улсын төсвийн 7.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өндөр сумын Дэнж, Оюут багийн төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулснаар, тухайн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | багуудын 10700 гаруй иргэд төрийн анхан шатны үйлчилгээг нэгдсэн байдлаар авах нөхцөл бүрдэж байна. Багийн үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлж, багт ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын байран дахь 30 гаруй удаагийн сургалтуудыг зохион байгуулж, багийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор багийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, буцалтгүй тусламж олгох, иж бүрэн гэр олгох, бичгийн хэрэгсэл, албаны жигд хувцсаар хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх ажлыг сайжруулахад зориулж сум, орон нутгийн төсвөөс нийт 373.5 сая төгрөг зарцууллаа.<br>Иргэдийн өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авах irgen.erdenet.mn вэб системд иргэд баг дээрээсээ цахимаар орж төрийн байгууллага, албан тушаалтанд санал, өргөдөл гомдлоо илэрхийлэх "Иргэний цахим булан"-гийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд 65.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Багийн үйл ажиллагааг сурталчлах, иргэд, байгууллагуудын оролцоог хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, иргэдээс гаргасан санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор нийт багууд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, эрчимжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж хүн амыг эрүүлжүүлэх эмчилгээ үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, сургалт сурталчилгаанд хамруулах, нутаг дэвсгэртээ олон нийтийн эргүүл хамгаалалтын ажлыг тогтмол зохион байгуулж мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 116. | 5.2. Төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг сайжруулна. | 5.2.1. Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварын түвшинг ахиулж, хариуцлагыг чангатгана | 5.2.1.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах | Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид | Тоо | 2023 | 10 | 2 | 65.0 | ОНТ | 2 | - | 100 | Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулах үеэр Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт шалгалтын үр дүн, сургалт, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах салбар хэлэлцүүлгийг хийн Орхон, Булган, Хөвсгөл аймгийн нийт 100 төрийн албан хаагчийг хамруулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу "Ёс зүйн дэд хороо " байгуулах зөвлөмжийг төрийн байгууллагуудад өгч арга зүйн удирдлагаар ханган 72 төрийн байгууллагад "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн байгуулан дэд хороодод 305 албан хаагчид томилогдон хараат бус, бие даасан зарчмаар ажиллаж байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 65 байгууллагын ёс зүйн дэд хороодоос ажилтан, албан хаагчдадаа ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт, үзүүлэн, сошиал мэдээлэл түгээх, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг нөлөөллийн олон талт арга хэмжээг тус бүр 3-12 удаа зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн байна. 2025 онд аймгийн төрийн байгууллагуудад нийт 21 гомдол мэдээлэл ирснийг хүлээн авч шалган 13 албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсоны дагуу уучлалт гуйхыг даалгах болох сануулах арга хэмжээг авсан байна |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 117. | | | 5.2.1.2. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн дэмжиж ажиллах | Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт | Хувь | 2023 | 50 | 80 | 300.0 | УТ ОНТ | 100 | 299.4 | 100 | Орон нутгийн төсвөөс 300.0 сая төгрөг шийдвэрлэсэн бөгөөд тус Ажлын хэсгийн 3 удаагийн хурлыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-ийг 2025 онд хэрэгжүүлэхэд төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2025 оны А/365 дугаар захирамжаар батлуулан төрийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан .Төлөвлөгөөний хэрэгжилт 100.0 хувьтай хэрэгжсэн ба хөтөлбөрийн хүрээнд 38 байгууллагын 44 албан хаагчдад 273.3 сая төгрөгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн. Мөн Удирдлагын академитай хамтран захиалгат 60 албан хаагчдад "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний өөрчлөлт" сэдэвт 16 цагийн танхимын сургалтын зардалд 3.6 сая төгрөг, Орхон, Булган, Хөвсгөл аймгуудын төрийн албан хаагчдын "Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 450 төрийн албан хаагчдад зохион байгуулахад 9.5 сая төгрөгийг шийдвэрлэсэн. |
| 118. | | | 5.2.1.3. Төрийн албан хаагчдыг богино, зорилтот, дунд хугацааны болон мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар төрөл бүрийн хэлбэрээр хамруулах | Мэргэшүүлэх сургалтын хамрагдалт | Хувь | 2023 | 50 | 80 | 65.0 | УТ ОНТ | 107 | 22.2 | 100 | Нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа анх томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад 9 байгууллагын 10, төрийн албан хаагчдыг дунд хугацааны мэргэшүүлэх зайн сургалтад 10 байгууллагын 26 төрийн албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц зайн сургалтад 7 байгууллагын 15 төрийн албан хаагч тус тус хамруулж, нийт 79 албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрууллаа. Мөн Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуультай хамтран "Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | боловсруулах, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй" богино хугацааны захиалгат сургалтад 4 байгууллагын 25 албан хаагч," Сэтгэлгээний өөрчлөлт" сургалтад Сургагч багш бэлтгэх сургалтад 1 байгууллагын 3 албан хаагчийг суралцах явцад хяналт тавин ажилласан. Орон нутгийн санхүүжилтээр захиалгат "Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй" сургалтыг 2025 оны 5 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус сургалтад аймгийн ИТХ, ЗДТГ болон Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох 30 албан хаагчид хоёр өдрийн турш сургалтад хамрагдсан. Төрийн албаны зөвлөл, "Мерит" төслөөс хамтран " Хувь хүний хөгжил"-ийн чиглэлээр 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, Захиргаа, удирдлагын газар (хэлтэс)-ын дарга, агентлагуудын хүний нөөцийн ажилтан, аймаг, сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга нарыг нийт давхардсан тоогоор 852 албан хаагч хамруулсан. |
| 119. | 5.3. Цахим төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна | 5.3.1. Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний мэдээллийн харилцааг сайжруулна | 5.3.1.1. Эрдэнэт И-Оффис системд холбогдсон бүх төрийн байгууллагын албан хаагчдад зориулсан системийн бүх дэд системүүдийн албан бичгийг цахим гарын үсгээр баталгаажуулах "Erdenet Eoffice eSign system" программ хангамжийг | Тоон гарын үсэг ашиглаж баталгаажуулсан баримт бичиг | Тоо | 2023 | - | 4,000 | 86.5 | ОНТ | 2329 | 85.8 | 58.2 | Эрдэнэт И-Оффис системд холбогдсон бүх төрийн байгууллага удирдах албан тушаалтнуудыг цахим гарын үсэг ашиглах нөхцөл боломжийг бүрэн дүүрэн хангасан программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Анх нэвтрүүлэхдээ байгууллагуудын албан бланк дээр төрийн сүлд, соёмбо ашиглагдахаар зохицуулалттай хийгдсэн ба хэрэглээний явцад зарим байгууллага өөрийн байгууллагын |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайжруулах | | | | | | | | | | | логоог бланк дээр хэрэглэх шаардлага үүсэж нэмэлт хөгжүүлэлтээр тухайн асуудлыг шийдвэрлэсэн. И-Оффис системийн цахим гарын үсгийн дэд системийг аймгийн хэмжээнд 21 байгууллага ашиглаж байна. Энэ онд нийт 2329 албан бичиг тоон гарын үсгээр баталгаажиж илгээгдсэн байна. |
| 120. | | | 5.3.1.2. Эрдэнэт И-Оффис, irgen.erdenet.mn системүүдийн Өргөдөл гомдлын системийг Smart Erdenet APP-тай холбож өргөтгөх, интеграци хийх программ хангамжийг сайжруулах | Smart Erdenet app-аар илгээгдсэн санал хүсэлт, өргөдөл гомдол | Тоо | 2023 | - | 250 | 54.5 | ОНТ | - | - | 0 | И-Оффис систем талаас Smart Erdenet APP-тай интеграци хийх API кодыг бэлтгэж гаргасан. Ухаалаг хот төслийн хүрээнд Smart-City аппликейшний хөгжүүлэлт үргэлжлүүлэн хийгдэхээр төлөвлөгдөж байгаа бөгөөд тус аппликейшнийг ашиглалтад оруулахад API холболт хийгдэж бүрэн ажиллана. |
| 121. | | | 5.3.1.3. Эрдэнэт И-Оффис систем Цахим судалгааны систем болон ААН-ийн Цахим бичиг тоот бичиг илгээж, хүлээн авах удирдлагын программ хангамжийг сайжруулах | И-Оффис системээр хийгдсэн судалгаа, баримт бичиг | Тоо | 2023 | - | 300 | 48.3 | ОНТ | - | - | 0 | 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хасагдсан тул уг ажил хэрэгжээгүй. |
| 122. | | | 5.3.1.4. Эрдэнэт И-Оффис системд холбогдсон бүх байгууллагуудад зориулсан Иргэдийг хүлээн авах, мэдээллээр хангах, Төрийн албан хаагчдыг үнэлэх “ERDENET EOFFICE RECEPTION SYSTEM” программ хангамж-ыг сайжруулах | Системээр дамжуулан төрийн албан хаагчдад өгсөн үнэлгээ | Тоо | 2023 | - | 200 | 88.0 | ОНТ | - | - | 0 | 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хасагдсан тул уг ажил хэрэгжээгүй. |
| 123. | | | 5.3.1.5. Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цахимаар хянах | Иргэдийн систем ашиглалтыг нэмэгдүүлэлт | Хувь | 2023 | 60 | 80 | - | - | 100 | - | 100 | Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цахимаар хянах боломжийг бүрдүүлэхээр irgen.erdenet.mn сайтыг хөгжүүлж 2020 оноос хэрэглээнд нэвтрүүлсэн |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боломжийг бүрдүүлж үйл ажиллагааг жигдрүүлэх . | | | | | | | | | | ба үйл ажиллагаа тогтмол хэвийн ажиллаж байна. Тус сайтаар 2025 онд 700 өргөдөл гомдол ирсэн байна. Нийт өргөдөл гомдлыг цахимаар 100 хувь хянаж байна. Иргэн, аж ахуйн нэгжийн системд нэвтрэхэд ашиглагддаг мессеж үйлчилгээг "Skytel" ХХК-тай хамтран ажиллаж тодорхой хэмжээний төлбөрийг урьдчилсан байдлаар төлсөн ба систем хэвийн ажиллаж байна. |
| 124. | | 5.3.2. Төлөвлөгөөт тооллого, бүртгэлийг явуулж төрийн мэдээллийн тогтолцоог бэхжүүлнэ | 5.3.2.1. Хүн ам, орон сууцны 2025 оны ээлжит тооллогын бэлтгэлийг хангах, тооллогыг зохион байгуулж явуулах | Хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь бүрэн алдаагүй бүртгэгдсэн өрх, хүн амын үзүүлэлтүүд | Хувь | 2024 | 100 | 100 | 150.0 | ОНТ | 100 | 119.6 | 100 | Хүн ам, орон сууцны завсрын тооллого нь иргэдийн төрд байгаа мэдээлэлд үндэслэн бүртгэлийн аргаар явагдсан. Өөрөөр хэлбэл төрийн 15 байгууллагын 30 мэдээллийн сангийн 61 үзүүлэлтийг Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй уялдуулан шалгаж, зөрүүтэй болон дутуу мэдээллийг нь тодруулах ажлыг 2025 оны 10 дугаар сарын 15-аас 12 дугаар сарын 15-ны өдрийг дуусталх хугацаанд зохион байгуулж явууллаа.. Энэ ажлын хүрээнд ҮСХ-оос ирүүлсэн хүрээн дэх 8791 өрхтэй 70151212 дугаарын утсаар холбогдож, 9900 өрхөд биечлэн очиж мэдээллийг нь тодруулах ажлыг 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хийв. Үүнээс гадна иргэдийг цахимаар тооллогод хамруулах зорилгоор 128 аж ахуйн нэгж, байгууллагын 1021 ажилтныг хамруулсан 22 удаагийн сургалтыг зохион байгуулж, 51027 иргэнийг ДАН системээр тооллогод хамрууллаа. Ингэснээр Хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь өрхийн болон өрхийн гишүүдийн мэдээллийг шинэчлэн, сангийн мэдээллийн чанарыг бүрэн сайжруулсан. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 125. | | | 5.3.2.2. Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллогыг зохион байгуулж явуулах | Малтай өрх, мал, тэжээвэр амьтдын тооллогын хамрагдалт | Хувь | 2024 | 100 | 100 | 26.2 | ОНТ | 100 | 8.5 | 100 | Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 7-оос 17-ны хооронд 20 чиглэлд зохион байгуулж явууллаа. Уг тооллогод 1596 өрх, 12 аж ахуйн нэгж, байгууллагын 169.6 мянган толгой мал, 168 толгой гахай, 7032 тахиа, 474 бүл зөгий тоологдлоо. Аймгийн тооллогын комиссоос 10 чиглэлд, сумдын тооллогын комиссоос 5 чиглэлд хяналтын тооллогыг хийхэд ямар нэгэн зөрчил илрээгүй. Мал, тэжээвэр амьтдын тооллогод малтай өрх, аж ахуйн нэгж, байгууллага, мал, тэжээвэр амьтдыг бүрэн хамруулсан. |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: НОГООН-ЭРДЭНЭТ ХОТ БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 6: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ЭРЧИМЖҮҮЛНЭ.** | | | | | | | | | | | | | |
| 126. | 6.1. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулна. | 6.1.1. Агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг бодлогоор дэмжинэ. | 6.1.1.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог багасгах төсөл хэрэгжүүлэх | Тухайн онд бууруулсан гэр хорооллын яндан | Тоо | 2023 | 275 | 60 | 150.0 | ОНТ | 63 | 130.0 | 100 | Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/846 захирамжаар байгуулан зохион байгуулж, 14003 айл өрх, 11 аж ахуйн нэгжийн хүчин чадлаар ялгаатай зуух, 33854 авто тээврийн хэрэгслийг хамрууллаа. Агаар бохирдлын эх үүсвэрийн тооллогын талаар 2 сумын нийт 22 багийн зохион байгуулагч нарыг хамруулан сургалт зохион байгуулсан.<br>Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний уналтыг багасгаж, найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2025 онд 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд орон нутгийн төсвөөс 13.1 тэрбум төгрөг төсөвлөн ажиллаж дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж ашиглалтад оруулснаар ачаалал өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож цахилгааны хүчдэлийн уналтыг шийдвэрлэсэн. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн 3500 м3 талбай бүхий 28-р цэцэрлэг, 3397 м3 талбай бүхий төрийн байгууллагуудын байранд халаалтын зориулалт бүхий 50 кВт-ын дулааны коллектор, цахилгаан эрчим хүчээр хангах 20 кВт-ын нарны зайн системээр дэмжигдсэн газрын гүний дулаанаар шийдвэрлэх 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг Смарт Энержи ХХК гүйцэтгэсэн. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршил тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим хүчээр бүрэн халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны яндан буулгасантай тэнцэж байна.<br>2025 онд Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц бүтээгдэхүүнийг 63 өрхөд хөнгөлөлттэй үнээр олгож, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулаа. |
| 127. | | | 6.1.1.2. Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Цагаан тоосны дэгдэлтийн бууралт | Хувь | 2023 | 30 | 50 | 50.0 | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ | 85 | 50.0 | 100 | Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийн хүрээнд Хаягдлын аж ахуйн элстэй 1432 га талбайн хуурайшилттай 85%-ийг технологийн 4 төрлийн аргаар норголт хийж, тоосны дэгдэлтийг бууруулж байна.<br>+дэгдэлт<br>Тоосны тархалтын зонхилох 3 чиглэлийн 121 га талбайд 5 төрлийн 1.8 сая.ширхэг мод, бутыг тарьж, арчлан ургуулж байна.<br>Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд Говил, Баянцагаан багийн Вокзалын хэсэг, Гаалийн газар, Эрдэнэт өртөө, Жаргалант сумаас нийт 500 иргэнийг хамруулж, |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | зөвлөгөө өглөө. Тоосны автомат 2 станцын тасралтгүй үйл ажиллагааг хангаж, дүнг www.Agaar.mn-д оруулж байна. Сургалт мэдээллийн хүрээнд ЕБС-ийн 120 сурагчдад сургалт, 35 иргэнд хаягдлын аж ахуйн танилцуулга, 2 удаа тайлангийн өдөрлөг, 6 удаа тоосжилттой бүсийн иргэдэд нөлөөллийн арга хэмжээг тус тус зохион байгууллаа. |
| 128. | | | 6.1.1.3. Гэр хорооллын алслагдсан багуудад байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж эхлэх | Нэвтрүүлсэн байгаль орчинд ээлтэй халаалтын тенхологи | Тоо | 2023 | 1 | 2 | 1450.0 | ОНТ, Олон улсын байгууллага | 2 | 1,292.5 | 100 | Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд БОАЖЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Баян-Өндөр сумын гэр хорооллын 19 м.кв хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусган айлуудтай гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй Яргуйт багийн 3500 м3 талбай бүхий 28-р цэцэрлэг, 3397 м3 талбай бүхий төрийн байгууллагуудын байранд халаалтын зориулалт бүхий 50 кВт-ын дулааны коллектор, цахилгаан эрчим хүчээр хангах 20 кВт-ын нарны зайн системээр дэмжигдсэн газрын гүний дулаанаар шийдвэрлэх 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг Смарт Энержи ХХК гүйцэтгэсэн. Төслийн гүйцэтгэлд НҮБ-ийн Хүүхдийн сан, аймгийн ЗДТГ хамтран хяналт тавин ажиллан туршил тохируулгын ажил явагдаж байна. Туршилт тохируулгын үеэр уурын зуухны галлагаа хийгдээгүй ба Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг сэргээгдэх эрчим |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хүчээр бүрэн халааж байна. Уг төсөл хэрэгжсэнээр 300 орчим айл өрхийн энгийн зуухны яндang буулгасантай тэнцэж байна. |
| 129. | | 6.1.2. Хөрсний бохирдол, доройтлыг бууруулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж хог хаягдлын нэгдсэн менежментийг бий болгоно | 6.1.2.1. Гэр хорооллын нүхэн жорлонг эко ариун цэврийн байгууламжаар өөрчлөх | Тухайн онд өөрчлөгдсөн эко ариун цэврийн байгууламж | Тоо | 2023 | 120 | 100 | 200.0 | ОНТ | 11 | - | 11 | Аймгийн хэмжээнд нүхэн жорлонгийн тооллого, судалгааны ажлыг сумдын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж нийт 14194 нүхэн жорлонг бүртгэлжүүлж, 2028 он хүртэл нүхэн жорлонгийн тоог 20 хувиар бууруулах төлөвлөгөө гарган баталгаажуулж, БОУАӨЯ-нд хүргүүлсэн.<br>Тооллогоор бүртгэгдсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эзэмшлийн 11 нүхэн жорлонг өөрчлүүлэхээр Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагуудыг хүргүүлж, шийдвэрлүүллээ.<br>“Гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэх” БОАЖЯ/202202080 тоот гэрээний дагуу Баян-Өндөр сумын Даваат, Шанд багт “Н ЭЙ БИ” ХХК-ийн хэрэгжүүлсэн 1000 эко ариун цэврийн байгууламж барих ажлын дутуу хийгдсэн 275 айлын бүхээгийн ажлыг гүйцэтгүүлж, бүрэн хүлээн авсан.<br>Нийтийн эзэмшлийн талбайд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрдэнэт голын голдирол дагуу Цэнгэлдэх хүрээлэнгийн ар талд нэг дор 6 хүн үйлчлүүлэх хүчин чадалтай нийтийн ариун цэврийн байгууламжийг барьж, ашиглалтад оруулсан байна. |
| 130. | | | 6.1.2.2. Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах | Ангилсан хог хаягдлын хэмжээ | Тн | 2023 | 150 | 300 | 50.0 | ОНТ | 447 | 3.0 | 100 | Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" НҮТББ-тай 3 хог хаягдлыг ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг үе шаттай зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. Аймгийн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хэмжээнд 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 8 нэр төрлийн 447 тн хог хаягдлыг цуглуулан төвлөрүүлж Улаанбаатар хот руу тээвэрлэн үйлдвэрүүдэд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан.<br>Мөн 10 үйлдвэр, ААНБ-ын 573.291тн аюултай хог хаягдал, 533ш ашиглалтаас гарсан дугуй, ерөнхий боловсролын 10 сургуульд хадгалагдаж байсан 264.7 кг устгах шаардлагатай химийн бодисыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлэн өгч устгууллаа. |
| 131. | | | 6.1.2.3. Уулын гуу жалга, голын голдирол дагуу хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлын цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах | Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ | М3 | 2023 | 667 | 667 | 35.0 | ОНТ | 674 | 15.0 | 100 | Орхон, Булган аймгийн хилийн зааг, орчны бүсийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан хог хаягдлын байршил, хэмжээг тодорхойлох судалгаагаар нийт 32 цэгт хуримтлагдсан 650 м3 хог хаягдлыг бүртгэлжүүлсэний дагуу цэвэрлэгээний ажлыг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ажилладаг 27 ААНБ-уудын 713 ажилчдын хамруулан 2025 оны 05 сарын 19-ний өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд зохион байгуулж, хог хаягдлыг иж бүрэн цэвэрлэж, бохирдлыг бууруулаа.<br>Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн сайдын өгсөн үүрэг даалгаврын хүрээнд нийт 76.4 км авто зам, төмөр замын дагуу ил задгай хаягдсан 24м3 хог хаягдлыг цэвэрлэж, дарж устгууллаа. |
| 132. | | | 6.1.2.4. Хог хаягдлын тогтвортой хөгжлийн боловсрол олгох | Сургалтад хамрагдсан иргэн болон сурагчид | Тоо | 2023 | 5600 | 5000 | 25.0 | ОНТ | 21520 | - | 100 | Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөрийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр аймгийн ИТХ-ын зөвлөлөөр 2024 оны хэлэлцүүлж 3 зорилт, 17 арга хэмжээг 89.3 хувийн гүйцэтгэлттэйгээр хэрэгжүүлэн ажилласан гэж дүгнэгдсэн. Аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрээр ХТГ-ыг Баян-Өндөр суманд шилжүүлсэн ба Баян-Өндөр |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | сумын ИТХ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/19 дугаар захирамжаар Баян-өндөр сумын хэмжээнд Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр батлах ажлын хэсгийг байгуулсан. “ Хог биш баялаг” ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн “Хог хаягдлын менежментийг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх” сургалт зохион байгуулж багийн Засаг дарга, багийн ажилтнуудыг сургалтад хамруулж ажилласны үр дүнд 21520 иргэнд мэдээлэл түгээж ажилласан байна. Мөн сумын тамгын газрын фэйж хуудас болон багуудын фэйж хуудсаар хог ангилан ялгах, хогоо хогийн саванд хийж хэвших дадал зуршил олгох мэдээллүүдийг тогтмол байршуулж давхардсан тоогоор 43575 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан. |
| 133. | | | 6.1.2.5. “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах | Төслийн хэрэгжилт | Хувь | 2023 | 50 | 100 | - | Гадаад зээл, тусламж | 90 | - | 90 | Төслийн хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах хүрээнд 6 төрлийн 12 машин механизм нийлүүлэх ажил бүрэн хийгдсэн ба эдгээр машиныг аймгийн Хот тохижуулах газарт хорооллуудын хог ачилтад бүрэн ашиглаж байна.<br>Гэрээний хүрээнд хог хаягдлыг татан зайлуулах машин механизмыг шинэчлэх ажил бүрэн хийгдсэн, үйлдвэрийг усаар хангах гүний худгийг гаргасан, үйлдвэрийн дэргэд цахилгааны дэд станцыг байгуулсан.<br>2025 оны байдлаар үндсэн барилга угсралтын ажил 95 хувь, дотор заслын ажил 90 хувь, гадна тохижилт, зам талбайн ажил 90 хувь, халаалтын ажил 90 хувь, агаар сэлгэлтийн ажил 80 хувь, цэвэр бохир усны ажил 90 хувь, хүчит тоноглол, дотор гэрэлтүүлгийн ажил 90 хувь, холбоо дохиоллын ажил 90 хувь, гадна |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | цахилгаан хангамжийн ажил 90 хувь, гадна гэрэлтүүлгийн ажил 90 хувь, нийт гүйцэтгэл 90 хувьтай байна. Барилга угсралтын ажил дууссан. |
| 134. | | 6.1.3. Гадаргын болон газрын доорх усны бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, хамгаалах | 6.1.3.1. Булаг шандын эх ундаргыг хамгаалж, тохижуулах | Тохижуулж хамгаалсан булаг шанд | Тоо | 2023 | 5 | 6 | 17.0 | ОНТ | 7 | 17.0 | 100 | Ар булгийн эх орчимд 1.5 метр өндөртэй, 100 метрийн урттай төмөр торон хашааг барьж, булгийн эх ундарга орчмын нийт 1000 м2 талбайг хашаажуулах ажлын гүйцэтгэгчээр “Агууч Жи Эм Би” ХХК шалгарч, булгийн эх орчмыг усны тэжээгдлийн бүсээр нь бүрэн хамгаалах, нөхөн сэргээх ажлыг гэрээний дагуу гүйцэтгүүлж, Баян-Өндөр сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Мөн Эрдмин ХХК нь Хүрэнбулгийн хамгаалалтыг сайжруулах ажлыг өөрсдийн зардлаар гүйцэтгэсэн. |
| 135. | | | 6.1.3.2. Газрын доорх усны чанарын хяналт, мониторингийн сүлжээг өргөтгөх | Мониторингийн цооног | Тоо | 2023 | 2 | 3 | 45.0 | ОНТ | 4 | - | 100 | Усны тухай хуулийн 6, 7 дугаар зүйлийн хэрэгжилтийн биелэлтийг хангаж газрын доорх усны хяналт-шинжилгээний цэгүүдийн тоог нэмэгдүүлэх, сүлжээг нягтруулах ажлын хүрээнд “Зэс Эрдэнийн хувь” ХХК-ийн үйлдвэрлэлийн талбайд байрлах газрын доорх усны хяналт-шинжилгээний 2 ш цооногт бүрэн автомат төхөөрөмж суурилуулан усны түвшин, температур, pH, эрдэсжилт, цахилгаан дамжуулалт, агаарын даралт зэргийг тогтмол хэмжиж байна. Ингэснээр хяналтын 4 цооногтой боллоо. |
| 136. | 6.2. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, нөхөн сэргээлтийг | 6.2.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 6.2.1.1. “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хүрээнд мод тарих цогц арга хэмжээг зохион байгуулах | Хөтөлбөрийн хүрээнд тарьсан мод | Тоо | 2023 | 3.4 сая | 4.1 сая | 20.0 | ОНТ | 5.2 сая | 20.0 | 100 | Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ногоон Эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих хавар, намрын ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, тарих модны байршил, тоо хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллалаа. Мод тарих олон талт арга хэмжээг зохион байгуулж төрийн болон хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор Дэнж багийн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрчимжүүлнэ | | | | | | | | | | | | | Тарлан толгойн таримал ойн төгөл, Баян-Овоот уулын орчим, Жаргалант сумын цэцэрлэгт хүрээлэн, Баян-Өндөр уулын Хүрэнбулагийн ам, Далиу булаг, А1001 авто зам дагуух ойн зурвас, Эрдэнэт хаалга орчим болон Хангал голын голдирол дагуух нийт 12 байршилд бүх нийтийн мод тарих ажлыг зохион байгууллаа. Мод тарих ажлыг зохион байгуулснаар 2022-2024 онд 4.839.686 ширхэг мод, 2025 онд 429.457 ширхэг мод тарьж Ногоон Эрдэнэт хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш өссөн дүнгээр 5.269.143 ширхэг мод тарилаа. |
| 137. | | | 6.2.1.2. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, таримал ойн талбайн хэмжээг нэмэгдүүлэх | Нэмэгдсэн талбайн хэмжээ | Га | 2023 | 215.46 га | 230 га | 225.0 | ОНТ | 316.86 | 325.8 | 100 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Баян-Өндөр сумын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаар эмнэлгийн арын ойн санд 2.7 га талбайд хамгаалалтын хашаа барилаа, Цагаанчулуутын аманд Япон улсын Оиска ТББ-ын дэмжлэгтэйгээр "Сайвар хээр" ХХК-аар 4 га талбайд хүргэлт ойжуулалт хийлээ, “Ногоон Эрдэнэт хөтөлбөрийг дэмжих оролцох тухай Ачит-Ихт ХХК-ийн гэрээний дагуу Далайн Хошууны шинэс ХХК болон Эрдмин ХХК Хангал голын голдирол дагуу 14.5 га талбайд татмын ойжуулалт, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын үйлдвэрчдийн эвлэлийн холбооны нэрэмжит ойн төгөл болон Д.Түмэнбаярын нэрэмжит ойн төгөл зэрэг байгуулагдаж ойн төглийг 1.5 га талбайд ойн төгөл, Эрдэнэтийн Дулаан цахилгаан станцын үнсэн сан орчим 1 га талбайд, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Цагаанчулуутын амны ойн сангийн 0.1 га талбайд, Эрдэнэт голын голдирол дагуу 1.1 га талбайд, Шанд багийн авто зам дагуу 0.5 га талбайд, нийт 22.7 га талбайд 429.5 мянган ширхэг мод шинээр тарьж, |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | ойжуулалт, ойн төгөл байгуулах ажил зохион байгуулж, ойжуулалт, өссөн дүнгээр 316.86 га талбайд мод тарьж, ойжуулалт ойн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ. |
| 138. | | | 6.2.1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ажилдаг ААНБ-уудын 2025 оны БОМТ-д биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нэг бүрчлэн тусгуулж батлуулан гүйцэтгүүлэх | Жилд нөхөн сэргээсэн газрын талбайн хэмжээ | Га | 2023 | 12 | 5 | - | Хувийн хэвшил | 21.43 | - | 100 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 7 ААНБ-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг тусгуулан БОУАӨЯ-аар батлуулан ажиллаж, хавар, намрын бүх нийтээр мод тарих ажлаар Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-аар орон тусгай хамгаалалтай Баян-Өндөр хайрханы зүүн талын энгэрт 10 га, Эрдмин ХХК-иар Хангал голын голдирол дагуу 2 га, Ачит-Ихт ХХК-иар Хангал голын голдирол дагуу 6 га, Зэс-Эрдэний хувь ХХК үйлдвэрийнхээ гадна талын сайжруулсан шороон авто зам дагуух ногоон зурвас 1.43га, Гал-Сэнтий ХХК -иар гурван замын ногоон зурваст 0.5га-д, Очир төв ХХК-иар Хангал голын голдирол дагуу 0.5га, Сархиа уулын урд энгэрт 1га талбайд тус тус биологийн нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлж, нийт 21.43 га талбайд мод бут сөөгийг тариулж, усалгаа арчилгааг тогтмол гүйцэтгүүлэн ажиллалаа. /нийт тарьсан модны ургалтын хувь 85%-тай ургаж байна./ |
| 139. | | | 6.2.1.4. Хотын ногоон байгууламж, ажиллах хүч, техник, тоног төхөөрөмж нэмэгдүүлэх | 1 хүнд ноогдох ногоон байгууламж | М2 | 2023 | 8 | 8.5 | 500.0 | ОНТ | 9.8 | 71.0 | 100 | Хотын ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын ажилд 2 удаа үзлэг шалгалт зохион байгуулсан. ЦНБ газар нь Амарын талбайд нийт 320 м2 талбайг зүлэгжүүлэн, 3 байршилд /4,5,6-р микр, Хөх Монгол цогцолборт/ 1400 ш мод бутыг тарьж, Хотын хэмжээний 82300 у/м ургамлан хашлага тэгшлэх, хэлбэржүүлэх, усалгаа, бордолт хийж, 6200 ширхэг мод сөөгийг хортон шавьжаас |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | сэргийлэн шохойлон, хор цацах, арчилгаа тордолтын ажлыг гүйцэтгэн ажилласан байна. Мөн хотын хэмжээнд цэцэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган 64000 ширхэг үрсэлгээ бэлдэж, тариалсан.<br>Хотын төвд Шинээр 4 байршилд 8830 м2 ногоон байгууламжийг шинээр бий болгож, нийт нарс, голт бор зэрэг 120 ш модыг тарьсан байна.<br>Нийт 54 га талбайд ногоон байгууламж бий бөгөөд 2025 онд Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд нөхөн сэргээлт, талбайд 422,500 ширхэг мод, бут, сөөгийг аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэд тарьсан бөгөөд 49,013 га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна. Баян-Өндөр уулын Хүрэн булгийн аманд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын үйлдвэрчдийн эвлэлийн холбоо, иргэн Б.Түмэнбаярын нэрэмжит ойн төгөл болон гэр хорооллын ногоон байгууламж нэмэгдүүлэх ажилд нийт 2.1 га талбай ногоон байгууламж нэмэгдүүлж нэг хүн ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 9.8-д хүрсэн байна. |
| 140. | | 6.2.2. Ундны усны хэрэглээний хэмнэлтийг бий болгох, бохир ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлнэ. | 6.2.2.1. Хаягдлын аж ахуйн бохир усыг цэвэршүүлэх, дахин ашиглах | Эргэлтэд оруулсан усны хэмжээ | Сая.м3 | 2023 | 85.3 | 91.2 | - | Эрдэнэт-Үйлдвэр ТӨҮГ | 96.1 | - | 100 | Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ын Ус хангамжийн цех нь 2025 онд хаягдлын аж ахуйн далангаас 96.1 м3 эргэлтийн усыг ашигласан байна. |
| 141. | | | 6.2.2.2. Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих | Аж ахуйн нэгж, иргэн | Тоо | 2023 | - | 3 | 150.0 | ОНТ Хувийн хэвшил | 6 | 30.0 | 100 | Орхон аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 3.6.1.2.4 дэх арга хэмжээ (Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжих)-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд бодлогын байгууллагын дэмжлэгтэйгээр хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэглээндээ саарал буюу техникийн усыг нэвтрүүлэхэд |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | талуудын оролцоо, санаачилгыг дэмжих зорилгоор Галсэнтий ХХК-тай хамтарч ус цэвэршүүлэх технологийг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй барилга, автомашин угаалга, мод үржүүлгийн газар, ноос угаах, газар тариалангийн салбарын төлөөллүүд оролцож, цаашид хэрхэн хэрэглээнд нэвтрүүлэх талаар санал бодлоо солилцлоо.<br>Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй автомашин угаалгын газруудад Усны тухай хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгааг шалгах, хаягдал ус дахин боловсруулах шийдлийг тодорхойлох судалгааны ажлыг аймгийн Байгаль орчны газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, "Эрдэнэт Ус ДТС" ОНӨХК хамтран зохион байгууллаа.<br>Хяналт шалгалт, судалгааны ажлын хүрээнд нийт 27 автомашин угаалгын газар хамрагдсан бөгөөд инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон 22, усны асуудлаа зөөврөөр шийдвэрлэдэг 5 газар ажиллаж байгаагаас 5 авто угаалгын газар 259тн саарал усыг гадна угаалгад дахин ашиглаж байна.<br>Аймгийн Засаг даргын захирамжаар 2025 оны А/893 дугаартай захирамжаар Саарал усыг хэрэглээнд нэвтрүүлээд байгаа 6-н аж ахуйн нэгжид 27.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН-ЭРДЭНЭТ ХОТ БҮЛГИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ҮР ДҮН 7. АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН ХОТЫГ БИЙ БОЛГОНО** | | | | | | | | | | | | | | |
| 142. | 7.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 7.1.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт | 7.1.1.1. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис хэрэглэгчдэд чиглэсэн сургалт, | Нөлөөллийн арга хэмжээний тоо | Тоо | 2023 | 1 | 2 | 5.0 | ОНТ | 3 | 5.0 | 100 | Аймгийн хэмжээнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг худалдах зөвшөөрөл авсан 11, эм ханган нийлүүлэх 1, энгийн үйлчилгээтэй 62, нийт 74 эмийн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана | бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ | нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | | | | | | | | | | | санд хяналт шалгалтын ажлыг 2025 оны 05-р сарын 06-аас 09-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Мансууруулах үйлчилгээтэй олсны ургамлыг устгах ажлын үр дүнг дээшлүүлэх нь бүсчилсэн зөвлөгөөн Орхон аймагт 2 өдөр зохион байгуулагдсан. "Анзаар-2" нэгдсэн арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулсан. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газартай хамтран бэлтгэсэн 2, Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газраас бэлтгэсэн 15 нийт 17 мэдээлэл, постерийг цахим орчинд суратлчилж 36541 иргэнд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг"-ын талаар мэдээллийг түгээн ажилласан. Урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийж ажилласнаар тайлант хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 4 бүртгэгдсэн байна. |
| 143. | | | 7.1.1.2. “Устгал-2025” нэгдсэн арга хэмжээг зохион явуулах | Устгал хийсэн талбай | Га | 2023 | 150 | 100 | 38.0 | ОНТ | 95.2 | 38.0 | 95.2 | Устгал-2025” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан, шаардагдах төсөв санхүүг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын тамгын газраас шийдвэрлүүлэн 06 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийн хооронд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж Орхон аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт 80 га талбайд Дроноор хор цацаж, 2 га талбайд гараар түүж шатааж, 7 га талбайд газар хагалж, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт 3,7 га талбайд ургамлын хорыг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | гараар цацаж нийт 92.7 га талбайд, Булган аймгийн Хангал сум Хялганат тосгоны газар нутагт үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-ын харьяа “Найрамдалын Эрдэнэс” хүүхдийн зуслан руу явах зам болон зуслангийн бүсэд байрлх тархцын 4 цэгт нийт 2.5 га талбайд Dji брэндийн хор цацагч Дроныг ашиглан устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн. |
| 144. | | | 7.1.1.3. “Анзаар” аяныг зохион байгуулах | Хамрагдсан иргэд | Тоо | 2023 | - | 1500 | 8.5 | ОНТ | 1567 | 10.0 | 100 | тамхитай тэмцэх газраас санаачлан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах зорилгоор "Анзаар-2" нэгдсэн арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Орхон аймгийн хэмжээнд зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид, эцэг, эх нарын нийт 1567 иргэнд 10 удаагийн 10 цагийн сургалт мэдээллийн ажлыг хүргүүлж, 5,300 ширхэг санамж, зөвлөмж, урьдчилан сэргийлэх чиглэлийн танилцуулга бүхий QR кодтой үзэг тарааж, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газартай хамтран бэлтгэсэн 3, Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газраас бэлтгэсэн 16 нийт 19 мэдээлэл, постерийг Цахим орчинд оруулж 41258 иргэнд мэдээллийг түгээж ажилласан. |
| 145. | | 7.1.2. Зонхилон тохиолдох гэмт хэргийн гаралтыг бууруулах олон талт арга хэмжээг | 7.1.2.1. Хүүхдүүдийг үе тэнгийн дээрэлхэлт, гэмт, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах. | Хүүхдийн эсрэг гэмт хэргийн гаралт | Тоо | 2023 | 9 | 0 | 5.0 | ОНТ | 2 | 5.0 | 77.8 | Сургуулийн өмнөх боловсролын 2, ерөнхий боловсролын 3 сургууль, цэцэрлэгийн нийт 152 хүүхэд, багачуудад зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>"Хүүхдээ сонсъё" чуулга уулзалтаар ерөнхий боловсролын 17 дугаар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлнэ | | | | | | | | | | | | сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хуулийн ойлголт сэдвээр 130 цагийн сургалт зохион байгууллаа. Монголын хүүхдийн спортын өвлийн 8 дугаар наадам Орхон аймагт зохион байгуулагдсантай холбогдуулан оролцогч 206 хүүхэд, 23 багш дасгалжуулагчид 25 дугаартай зөвлөмж өгч хариуг аван, эргүүл шалгалт хийж ажилласан. "Хүүхдээ анхааръя" арга хэмжээний хүрээнд 22 дугаар цэцэрлэгийн багш, эцэг эх, асран хамгаалагч нарт Өсвөр насны хүүхдэд анхаарах асуудал, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөрчлийн тухай хуулийн ойлголт сэдвээр, 14 дүгээр сургуулийн 6-12 дугаар ангийн 1530 сурагчдад Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвээр, "Орхон эмпати" сургуулийн дотуур байрны 15 сурагчдад Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөрчлийн тухай хуулийн ойлголт сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Боловсролын байгууллагатай хамтран Ерөнхий боловсролын 46 сургуулийн ахлах, дунд ангийн нийт 10510 сурагчдыг хамруулан сургалт нөлөөллийн ажил арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 144 багш. нийгмийн ажилтан нарт "Хүүхдийн эрх, хувь хүний нууц" сэдвээр 6 удаагийн 6 цагийн сургалтыг зохион явуулсан. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийн дүн мэдээнд тулгуурлан зохион байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд төрийн байгууллага 90, төрийн бус байгууллага 64 байгууллагуудтай |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хамтран ажиллалаа. Тайлант хугацаанд онтой харьцуулахад хүүхэд оролцсон гэмт хэрэг 42.1 хувиар буурсан байна. |
| 146. | | | 7.1.2.2. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр аймгаас орж, гарах авто замуудад пост гаргаж урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Малын хулгайн гэмт хэргийн гаралт | Тоо | 2023 | 2 | 0 | 13.0 | ОНТ | 0 | 2.1 | 100 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 7.0 сая төгрөгийг зарцуулан ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2025 оны А/40 дугаар тушаалаар баталсан “Мал, мах-2025” хэсэгчилсэн арга хэмжээний батлагдсан удирдамжийн дагуу аймгийн нутаг дэвсгэрт уг арга хэмжээг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Цагдаагийн газрын дарга, Мал эмнэлгийн газрын дарга нараар батлуулж, хэрэгжилтийг хангах холбогдох хэлтэс, тасаг болон мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>Удирдамжийн дагуу 21 хоногийн хугацаатай 2 чиглэлд 2 тээврийн хэрэгсэлтэй 4 алба хаагч, мал эмнэлгийн газрын 2 алба хаагч нийт 6 алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж 2 зөрчил илрүүлж Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу 300000 төгрөгийн шийтгэл оногдуулж ажилласан.<br>Аймгийн хэмжээнд мал, мах худалдан борлуулдаг “Таван-Эрдэнэ” бөөний цэг, Хүлэг хүнсний зах, “Энх” худалдааны төв, гадаад орнуудад мах экспортолдог “Мон-Гема” ХХК, “Эрдэнэт мах маркет” ХХК, “Эрд мийт” ХХК, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Идэрбаялаг” “Хатан-Оюу”, “Орхон-Энхбүтэмж” зэрэг 3 хиаман цех, мал мах, малын гаралтай түүхий эд худалдан борлуулдаг 200 гаруй ченж, нийтийн хоолны үйлчилгээ явуулдаг 34 аж |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан. Хяналтаар стандартад нийцэхгүй камер суурилуулсан, хадгалах хугацаа хэт богино, үзэгдэх орчныг бүрэн хянах боломжгүй зэрэг зөрчил илэрсэн 16 аж ахуйн нэгж, байгууллагаас 4 зөрчлийг газар дээр нь арилгуулж, хугацаатай 12 мэдэгдэл өгч үр дүнг тооцож ажилласан.<br>Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдүүдийн судалгаанд баяжилт хийж шинээр 2 сэжигтэй этгээдийг Цагдаагийн байгууллагын судалгаа, хяналтын Patrol2.police.gov программд оруулж бүртгэлжүүлсэн.<br>Тайлант хугацаанд мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна. |
| 147. | | | 7.1.2.3. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн мэдлэг, санхүүгийн боловсрол олгох “Цахим+Залилан” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээ | Тоо | 2023 | 2 | 2 | 5.0 | ОНТ | 3 | 5.0 | 100 | Аймгийн хэмжээнд “Хэт ашигтай саналуудын ард хохирол нуугддаг” нөлөөллийн арга хэмжээг нэг сарын хугацаатай залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн газрын дарга, Аймгийн хууль, эрх зүйн хэлтсийн даргаар батлуулсан төлөвлөгөө гаргаж аймгийн томоохон төрийн болон төрийн бус байгууллагуудад төлөвлөгөөг хүргүүлэн хамтран ажиллаж байна. Тус арга хэмжээний хүрээнд иргэд олон нийтэд сэрэмжлүүлэг галын авлага 5 төрлийг 1195 ширхэг, зурагт хуудас 3 төрлийг 1000 ширхэг, цагдаагийн газрын цахим хуудсанд постер-12, видео, рийл мэдээ мэдээлэл-3 бэлтгэж хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумуудын Засаг даргын тамгын газартай хамтарч нийт 2520 айл өрхөөр орж иргэдэд залилах |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | гэмт хэрэгт хохирохгүй байх талаар урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж ажилласан. Тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 45 төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан албан хаагч нарт сургалт мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. |
| 148. | | | 7.1.2.4. Орон нутгийн телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг иргэд олон нийтэд сурталчлах | Гэмт хэрэг илрүүлэлт | Хувь | 2023 | 59.7 | 60.0 | - | - | 61.6 | 6.0 | 100 | Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс орон нутгийн Номин ТВ-тэй жилийн турш хамтран ажиллах гэрээ байгуулан “Хуулийн цаг” нэвтрүүлгийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэн, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, хууль эрх зүйн мэдээлэл тухай бүр иргэд, олон нийтэд өгч ажиллаж байгаа болно. |
| 149. | | | 7.1.2.5. “Хүн бүр байгаль хамгаалагч” арга хэмжээг зохион байгуулах. | Хүрээлэн байгаа орчны гэмт хэргийн гаралт | Хоо | 2023 | 6 | 0 | 5.0 | ОНТ | 1 | - | 83.3 | 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр баталсан “ХҮН БҮР БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ” уриа дор зохион байгуулагдах “БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу Орхон аймгийн нутаг дэвсгэрт ““БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” хэсэгчилсэн арга хэмжээг 4 чиглэлээр явуулах салбар төлөвлөгөөг баталсан. Аймгийн Засаг даргаар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай захирамж гаргуулан мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтэн нартай хамтран хяналтын постууд болон хөдөлгөөнтөөр шалгалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Орхон аймгийн нутаг дэвсгэрт Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр "ЭКО-2025" арга хэмжээний хүрээнд аймгийн нутагт дэвсгэрт мод, модон материалаар хашаа байшин барьж байгаа болон мод буулгасан иргэдийн бичиг баримтад хяналт, шалгалтыг зохион байгуулж, шалгалтаар ямар нэг гэмт хэрэг |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | илрээгүй байна. Хүйтний улирал эхэлж буйтай холбогдуулан түлээний мод бэлтгэх хууль бус үйлдлүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж зохих зөвшөөрөлгүй 4м$^3$ шинэс төрлийн мод хууль бусаар бэлтгэж мод модон материалын гарал үүслийн гэрчилгээгүйгээр тээвэрлэсэн 1 гэмт хэргийг илрүүлсэн. |
| 150. | | | 7.1.2.6. Цагдаагийн байгууллагыг авто машин, техник хэрэгслээр хангах | Техник хэрэгслийн хангалт | Хувь | 2023 | 60 | 70 | 50.0 | ОНТ | 70 | 141.0 | 100 | Цагдаагийн газарт 2025 онд Цагдаагийн газрын дээвэр, гадна фасадны засвар, гэрэлтүүлгийн ажилд 109.5 сая төгрөг, энгэрийн камер, сүлжээний тоног төхөөрөмж худалдан авахад 350.0 сая төгрөг, олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулах зардалд 390.0 сая, хөдөлгөөнт эргүүлийн авто машины шатахууны зардалд 20.0 сая төгрөгийг тус тус баталж гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон. Мөн Баян-Өндөр сумын 141.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хундай стариа маркын авто машин хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Ингэснээр техник хэрэгслийн хангалт 70 хувьд хүрсэн. |
| 151. | | 7.1.3. Гэмт хэргийг бууруулах чиглэлээр зорилтот бүлэгт чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулна | 7.1.3.1. “Илрүүлэлт-Оргодол-2025” нэгдсэн арга хэмжээний зохион байгуулах | Хэрэг бүртгэлийн хэрэг | Тоо | 2023 | 457 | 400 | 8.0 | ОНТ | 926 | - | 0 | Хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж 2025 оны 5 дугаар сарын байдлаар “Сар шинэ 2025”, “Илрүүлэлт оргодол”, “Шийдвэрлэлт”, “Carback”, “Арлын дугаар”, “Ломбард хяналт”, “Халаас”, “Бүртгэл” зэрэг ерөнхий болон тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Баян-Өндөр сумын Хөршийн холбоодын ахлагч нарын судалгааг шинэчлэн гаргаж, нийт 1098 хөршийн холбооны ахлагчийг бүртгэлжүүлэн ажиллаж байна. Хөршийн холбооны ахлагч нар нь хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын цагдаагийн газар болон багийн ажлын албатай хамтран байнгын |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | эргүүл, шалгалтын аян зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна. Эргүүл, шалгалтын явцад нийт 75 зөрчил, дутагдал илрүүлэн холбогдох байгууллагуудад мэдээлж, зохих арга хэмжээ авсан байна. Цагдаагийн газрын цахим хуудаст байршуулсан мэдээллээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 1264 видео контент, рийл, постеруудыг байршуулж олон дагагчтай групп цахим хуудсуудад түгээж нийт 804524 иргэний хандалтыг авч ажиллалаа. |
| 152. | | | 7.1.3.2. Архины хамаарал бүхий иргэдийг “Албадан эмчлэх төв”-д явуулах, эмчлүүлэх ажлыг зохион байгуулах. | Эмчлүүлсэн иргэд | Тоо | 2023 | - | 10 | 8.0 | ОНТ | 34 | 6.0 | 100 | Албадан эмчилгээний зардалд 6.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, Баян-Өндөр, Жаргалант сумын багуудын нутаг дэвсгэрт архины хамааралтай, орон гэргүй согтуурах, мансуурах донтой 55 иргэнийг эрүүл мэндийн нэгдсэн үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл мэндээрээ тэнцсэн 34 иргэнийг албадан эмчилгээнд хамруулах зорилгоор "Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай" хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гаргуулж Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 437 дугаар ангид 34 иргэнийг хүлээлгэн өгсөн. Архины хамааралтай, орон гэргүй тэнэмэл иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Халамж үйлчилгээний газартай хамтарч “Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй” төрийн бус байгууллагын нийгэмшүүлэх байранд орон гэргүй тэнэмэл 32 иргэнийг байршуулсан одоо байнгын амьдарч байгаа 35 иргэн байна. Гэмт хэрэг, зөрчил |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | үйлдэж болзошгүй иргэдэд хяналт тавин ажиллаж байна. |
| 153. | | | 7.1.3.3. Гэр бүлийн хүчирхийллийн “Хамтарсан баг”-ийг чадваржуулах сург алтыг зохион байгуулах. | Зохион байгуулсан сургалт | Тоо | 2023 | 3 | 5 | 5.0 | ОНТ | 5 | - | 100 | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээр Монгол Улсад анх удаа анхан шатанд буюу сум, хороодод хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнууд ажиллаж эхэлсэн. Тухайн нийгмийн ажилтан баг дээрх хамтарсан багийн нарийн бичгээр ажиллах тул нийгмийн ажилтнуудыг чадавхжуулахаар Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг нийгмийн ажлын онол арга зүйгээр чиглүүлэх, мэргэшүүлэх 40 цагийн сургалтад багуудад шинээр томилогдсон 24 нийгмийн ажилтнуудыг хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нуугдмал далд хэлбэрийг илрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд Баян-Өндөр сумын ИТХ, Засаг даргын тамгын газар, Сэтгэл зүйн цогц боловсролын төвтэй хамтран “Нэг кейс, нэг нийгмийн ажилтан” аяныг 2025 оны 05 дугаар сарын 21-нээс 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл 1 жилийн хугацаатай зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөөг гарган, 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр нээлтийн арга хэмжээ, сэтгэл зүйч нарын сургалтаар эхлүүлээд байна. Тус аянд Баян-Өндөр сумын нийт 26 багийн “Хамтарсан баг”-ууд оролцож, 1 жилийн турш гэр бүлийн хүчирхийллийн кейс дээр улирал бүр хяналт үнэлгээ хийлгэх хэлбэрээр оролцох, аян дуусах хугацаанд хамгийн үр дүнтэй ажилласан 5 нийгмийн ажилтан, “Хамтарсан баг”-ийг шалгаруулж, урамшуулсан. Баг хариуцсан |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хэсгийн байцаагч нарын гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарын хяналтын хувийн хэргийн баяжилтад сар бүр хяналт тавьж, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд “Хамтарсан баг”-ийн идэвх оролцоог сайжруулах, чадавхжуулах зорилгоор “Хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” ажлын удирдамжийн дагуу Баян-Өндөр сумын нийт 20 багийн “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн зааварчилж ажилласан. |
| 154. | | | 7.1.3.4. Жиндэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аян арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах. | Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг хэрэг | Тоо | 2023 | 25 | бууруулна | 5.0 | ОНТ | 16 | 5.0 | 100 | Иргэд олон нийтэд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр “Жендэрийн ерөнхий ойлголт”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл”-ийн тухай сургалтыг зохион байгуулж 5 байгууллагын 152 албан хаагч хамрагдаж, тэдний жендэрийн тухай мэдлэг ойлголт нэмэгдсэн. Статистик мэдээгээр Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг хэрэг 12 бүртгэгдэж мнөх оноос 1 дахин бага байна. Мөн Цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтнуудад “Жендерт суурилсан хүчирхийлэл, түүний ойлголт” сэдвээр 1 удаагийн 45 минутын, мөн Жендэрийн Үндэсний хорооны ментор, шинжээч багш нараар алба хаагчдад “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого” сэдвээр 1 цагийн сургалтуудыг тус тус зохион байгуулсан.<br>Статистик мэдээгээр Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг хэрэг 16 бүртгэгдэж өмнөх оноос буурсан байна. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 155. | | | 7.1.3.5. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд хэмжилзүйн баталгаажуулалтаар дэмжлэг үзүүлэх | Согтуурлын зэрэг хэмжигч багажийг шалгах төхөөрөмж | Тоо | 2023 | 0 | 1 | 20.0 | ОНТ | 1 | 10.0 | 100 | Орхон аймгийн Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар амьсгал дахь спиртийн агууламж тогтоох багажийг шалгах ажлын эталон /AlcoCal W2/ -ыг худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 13 ширхэг амьсгал дахь спиртийн агууламж тогтоох багаж /драггер/ -ийг шалгалт баталгаажуулалтад хамруулсан байна. Цусны даралтын аппарат болон техникийн манометр шалгах иж бүрдэл эталоныг авах талаар Шадар сайд СХЗГазрын дарга, удирдлагуудад танилцуулсан.<br>Сорьцын хяналт хэрэгжүүлэх жин хэмжүүрийг хяналт шалгалт хийхэд ашиглаж байна. |
| 156. | | 7.1.4. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөр"- ийн хэрэгжилтийг хангана | 7.1.4.1. "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2025 аяныг зохион байгуулах | Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг | Тоо | 2023 | 34 | бууруулна | 18.0 | ОНТ | 42 | 15.0 | 0 | Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/712 дугаартай зөвлөмжөөр ирүүлсэн "Орон нутгийн зам-хөдөлгөөний соёл" нэгдсэн арга хэмжээг зохион явуулах удирдамж, чиглэл, хуваарь, төлөвлөгөөг авч Замын цагдаагийн тасаг, хэсгийн алба хаагчдад Жаргалант сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа алба хаагчдад тус тус танилцуулсан.<br>Арга хэмжээний хүрээнд зарцуулагдах 15.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдүүлж, алба хаагчдын тээврийн хэрэгслийн шатахуун, хоол, анхааруулах самбарт байрлуулах анонс, тараах материал зэргийг хэвлэлтэд өгч байрлуулан иргэд жолооч нарт анхааруулга сэрэмжлүүлэг өгч ажиллаж байна. Мөн Цагдаагийн Ерөнхий газрын Тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн дагуу "ШУГАМАН ЭРГҮҮЛ, ЦАГИЙН МЕНЕЖМЕНТ"-г арга хэмжээг орон нутагт зохион байгуулж эхлээд байна. Тус арга хэмжээний хүрээнд Замын цагдаагийн тасгаас 2 алба |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хаагчийг Шугаман эргүүлээр 24 цагийн турш Улсын чанартай А-1001 зам дээр эргүүл хяналт шалгалтуудыг хийлгэн ажиллаж байна. Энэ он гарсаар Улсын чанартай А-1001 зам дээр зам тээврийн осол хэрэг бүртгэгдээгүй байна. Замын цагдаагийн тасгийн зүгээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс 8 төрлийн REEL-ийг хийж цахим орчинд байршуулан иргэд олон нийтэд сурталчлан ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд зам тээврийн осол хэрэг ихээр гардаг байршлуудын судалгааг гарган орон нутгийн төсвийн 120.0 сая төгрөгийн санхүүжилтээр MNS 5968-2009 стандартын дагуу 14 байршилд хурд сааруулагч хийсэн. Мөн явган хүн холбогдсон зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр 19 байршилд шөнийн цагт гэрэлтдэг лед гэрэлтэй явган хүний гэрэлт гарцыг шинээр хийлгэсэн.<br>Өмнөх онд явган зорчигч зам тээврийн осолд өртсөн, хохирсон 51 зөрчил бүртгэгдсэн бол энэ онд 42 зөрчил бүртгэгдэж буурсан үзүүлэлтэй байна. |
| 157. | | | 7.1.4.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой” Тэмцээн зохион байгуулах | Хүүхдийн эсрэг гэмт хэрэг | Тоо | 2023 | 9 | 0 | 17.0 | ОНТ | 2 | - | 77.7 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдийн дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2025" тэмцээнийг 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээнд 13 цэцэрлэгийн 110 хүүхэд багш нарын хамт оролцсон. Статистик мэдээгээр хүүхдийн эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн байна. |
| 158. | | | 7.1.4.3. Дэлхий нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг “Автомашингүй өдөр” арга хэмжээг зохион байгуулах | Тээврийн хэрэгслийн эсрэг гэмт хэрэг | Тоо | 2023 | 34 | буурна | 5.0 | ОНТ | 42 | - | 0 | "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах" баярын өдрийг автомашингүй өдөр болгон зарлаж Амарын талбайгаас Сүмийн уулзвар хүртэлх авто замыг 10:00-22:30 цагийн хооронд түр хааж, |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | хамгаалалт хөдөлгөөн зохицуулалтад Замын цагдаагийн тасгийн алба хаагчид ажилласан.<br>Өмнөх онд явган зорчигч зам тээврийн осолд өртсөн, хохирсон 51 зөрчил бүртгэгдсэн бол энэ онд 42 зөрчил бүртгэгдэж буурсан үзүүлэлтэй байна. |
| 159. | | 7.1.5. Олон нийтийн цагдаагийн ажлыг идэвхижүүлж, иргэдийн амар тайван байдлыг хангана | 7.1.5.1. Олон нийтийн цагдаагийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, дэмжин урамшуулах, ажлыг зохион байгуулах | Олон нийтийн цагдаа | Тоо | 2023 | 45 | 45 | 702.0 | ОНТ | 35 | 390.0 | 77.8 | Олон нийтийн цагдаагийн ажилтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 390.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулсан.<br>Баян-Өндөр суманд 33, Жаргалант суманд 2, нийт 35 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэн, багуудын хэсгийн байцаагчийн хамт болон замын цагдаагийн тасаг, урьдчилан сэргийлэх тасагт тус тус ажилласан.<br>Тайлант хугацаанд олон нийтийн цагдаа нар давхардсан тоогоор гэмт хэрэг, зөрчлийн 975 хамгаалалт, замын хяналт шалгалт явган эргүүлд 1774 удаа, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн 729 хүнийг цагдаагийн байгууллагад хүргэж ажилласан. Мөн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг 505 аж ахуй нэгжид мэдээлж, зөрчил 6131 илрүүлж, урьдчилан сэргийлэх чиглэлээр 829 аж ахуй нэгж, 10410 иргэнд мэдээ, мэдээлэл, тараах материал сэрэмжлүүлэг хүргэж, албан шаардлага, мэдэгдэл, зөвлөмжийг 138 хуулийн этгээд, 107 иргэнд хүлээлгэн өгсөн. |
| 160. | | 7.1.6. Шүүх шинжилгээний төрөл зүйл нэмэгдэнэ | 7.1.6.1. Шүүхийн шинжилгээний хэлтсийн лабораторийн барилгыг өргөтгөх | Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | - | 50 | 1800.0 | УТ | 100 | 196.0 | 100 | Шүүх шинжилгээний хэлтсийн байрлаж байгаа орон нутгийн өмчийн байранд хот хоорондын автобусны билетийн касс үйл ажиллагаа явуулж байсан 2 өрөөг суллаж, хэлтсийн байртай холбох зураг төслийг Хот байгуулалт, барилга захиалагчийн албаар хийлгүүлэн, шаардагдах зардал 143.5 сая төгрөгийг орон нутгийн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | төсөвт тусган батлуулж, хэлтсийн байранд их засварыг хийж дуусгасан. Ингэснээр 2009 оноос хойш анх удаагаа тус хэлтсийн байранд их засвар хийгдэж засварын ажлын хүрээнд гистологийн шинжилгээний лабораторийн өрөөг стандартад нийцүүлэн засварлаж, шинжээч эмч нарын өрөө, криминалистикийн шинжилгээний лаборатори, шүүх анагаах ухааны архивын өрөөг шинээр бий болгож, шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж дүгнэлт гаргах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. |
| 161. | | 7.1.7. Архивын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангана | 7.1.7.1. Хуульд заасны дагуу Архивын тасгийн орон тоог нэмэгдүүлэх, архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор гэрээт ажилтан ажиллуулах | Нэмж ажиллуулсан ажилтан | Тоо | 2023 | 2 | 2 | 30.0 | ОНТ | 2 | 27.0 | 100 | ЗГ-ын 2025 оны 37-р тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар Архивын хэлтсийн орон тоог 8, үүнээс төрийн захиргааны албан хаагч 3, төрийн үйлчилгээний (ТҮМ ангиллын) албан хаагч 5 байхаар баталсны дагуу төрийн үйлчилгээний албан хаагчдыг томилсон.Хэлтсийн даргын албан тушаалд төрийн албаны сонгон шалгаруулалтыг зарласан ба 2025 оны 12 дугаар сарын 17-нд тусгай шалгалт зохион байгуулагдаж, тэнцсэн иргэнийг томилуулахаар нэр дэвшүүлсэн. ТАЗ-ийн тогтоол гарсан. Хэлтсийн дарга томилогдсоны дараа Төрийн захиргааны 2 албан хаагчийг (Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч, Архивын бодлого, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн) томилохоор ажиллаж байна.Архивын баримтыг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөр цахимжуулалт хариуцсан 2 ажилтныг ажиллуулсан. |
| 162. | | | 7.1.7.2. Ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, техник тоног төхөөрөмжөөр хангах | Тоног төхөөрөмжийн хангалт | Хувь | 2023 | 60 | 80 | 30.0 | ОНТ | 80 | 66.7 | 100 | 2025 онд орон нутгийн төсвийн 30.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сан хөмрөгийн өрөөний чийгшлийг хянах автомат чийгшүүлэгч, баримтын цахим нөөц хувь |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | хадгалах зориулалт бүхий дотоод сүлжээний орчинд ажиллах файл хадгалах сан (16 ТВ багтаамж бүхий 2 ширхэг Seagate Nas хаардтай), олон үйлдэлт хэвлэгч, сканнерийг (А3, А5) худалдаж авсан. Мөн 36.3 сая төгрөгөөр 5 ажилтанд иж бүрэн компьютер, тоног төхөөрөмжөөр хангаж, 2 өрөөнд засвар хийж тохижуулснаар шинээр томилогдож буй албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. |
| 163. | | 7.1.8. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ | 7.1.8.1. Дэвшилтэт камер бүхий ухаалаг гэрлэн дохиог авто замын уулзваруудад суурилуулах | Ажлын гүйцэтгэл | Хувь | 2024 | - | 100 | 500.0 | ОНТ | 100 | 358.0 | 100 | Замын хөдөлгөөн зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр хотын төвийн 7 уулзварын гэрлэн дохиог автоматжуулах, алсын удирдлагад шилжүүлэх ажлыг "Прожект деволопмент солюшин" ХХК гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Эдгээр 7 уулзварын гэрлэн дохиог “Теле камерын хяналтын дэд төв”-ийн инженерүүд болон Замын цагдаагийн тасгаас 1 албан хаагч тогтмол ажиллаж, замын хөдөлгөөний нөхцөл байдлыг камераар хянан хөдөлгөөний ачаалал ихэссэн үед гэрлэн дохиог камерын тусламжтайгаар зохицуулан ажиллаж байна. |
| 164. | | | 7.1.8.2. Хотын камержуулалтад засвар үйлчилгээ, шинэчлэл хийж хэвийн үйл ажиллагааг тогтмол хангах | Хэвийн ажиллаж байгаа камерын хэмжээ | Хувь | 2024 | 75 | 100 | 500.0 | ОНТ | 80 | 1,300.0 | 20 | 2025 онд орон нутгийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэ, Шанд, Их залуу, Булаг багуудад тусгай зориулалтын камер 51 ширхэг, 360 градусын эргэлттэй камер 17, нэг чиглэлийн камер 120, нийтдээ 188 ширхэг хяналтын камерыг дагалдах хэрэгслийн хамт суурилуулсан.<br>Ингэснээр аймгийн хэмжээнд 26 багт нийтийн эзэмшлийн зам талбайд өссөн дүнгээр чанарын стандартад нийцсэн нийт 1475 ширхэг камер Теле камерын хяналтын дэд төвд холбогдсоноос нэг чиглэлийн 1186 ширхэг, PTZ хөдөлгөөнт 196 ширхэг, хэт ягаан туяаны 2 ширхэг, ANPR дугаар |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | таних зориулалттай 41 ширхэг, царай таних 50 ширхэг камер суурилуулан ажиллуулж байна Дахуа системийн AI-д суурилсан Smart City системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү систем нэвтэрснээр хүний гадна төрх болон царайгаар, автомашины зөвхөн дугаараар бус өнгө хэлбэр хэмжээгээр хайх, явсан замын маршрут гаргах гэх мэт давуу талуудтай болсон.<br>Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 74 камерын цэгт, 420 гаруй камерын сэлбэг хэрэгслийг засварлаж, 14км урт шилэн кабель залгаж ажилласан байна. Ингэснээр нийт камерын 80 хувь нь хэвийн ажиллагаатай байна. |
| 165. | 7.2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоо чанарыг нэмэгдүүлнэ | 7.2.1. Цэргийн бэлтгэл нөөцийн чадавхыг нэмэгдүүлнэ | 7.2.1.1. Оюутан цэрэг байрлах зөөврийн байрыг үргэлжлүүлэх | 100 оюутан цэрэг байрлах боломжтой орчин нөхцөл бүрдүүлсэн байдал | Хувь | 2024 | 40 | 60 | 65.0 | ОНТ | 100 | 25.0 | 100 | Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтад зориулсан 100 цэргийн алба хаагч байрлах 3х6 хэмжээтэй зөөврийн байрыг Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд байрлуулж оюутан цэрэг байрлах орчин нөхцөлийг 100 хувь бүрдүүллээ. Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалт 2025 оны 04 дүгээр сарын 06-наас 08 дугаар сарын 11-ний хооронд зохион байгуулсан. |
| 166. | | | 7.2.1.2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын төв байгуулах | Сургалтын төвийн стандартыг хангалт | Хувь | 2024 | - | 25 | 80.0 | ОНТ | 25 | 60.0 | 100 | Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын дадлагын буудлагын талбай бүрэн хэрэгжиж стандартын хангалт 25 хувьтай болсон. |
| **ОРХОН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ: ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ЭРДЭНЭТ ХОТ БҮЛГИЙН ХҮРЭЭНД<br>САЛБАРЫН ҮР ДҮН 8: АЯ ТУХТАЙ АМЬДРАХ ОРЧИН БҮРДҮҮЛНЭ** | | | | | | | | | | | | | | |
| 167. | 8.1. Иргэдийн амьдарч буй орон сууцны орчин нөхцөлийг сайжруулн | 8.1.1. Инженерийн хангамжтай орон сууцны тоог | 8.1.1.1. Инженерийн хангамжтай нийтийн болон амины орон сууцны хорооллуудыг барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх | Ашиглалтанд орсон орон сууцны айл өрх | Тоо | 2023 | 860 | 1523 | - | Хувийн хэвшил | 1326 | - | 70.3 | Аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 7 төсөл Оюут, Чандмань Найрамдал, багуудад тус тус баригдаж байгаагаас 2025 онд 1326 айлын орон сууц ашиглалтад орсон. |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 168. | а | нэмэгдүүлнэ | 8.1.1.2. Инженерийн хангамжтай нийтийн орон сууцны хорооллуудыг гэр хорооллын багуудад барьж аймгийн орон сууцны санг нэмэгдүүлэх | Орлогод нийцсэн орон сууц төслийн хэрэгжилт | Хувь | 2023 | 75 | 100 | 7500.0 | Хувийн хэвшил , иргэн | 90 | - | 60 | Аймгийн хэмжээнд дахин төлөвлөлтийг хийхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэрлэсний дагуу Уурхайчин багт 1.3 га газарт дахин төлөвлөлтийн ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулан төсөл эхлүүлснээр хэрэгжилт 40 хувьтай, Инженерийн хангамжтай нийтийн орон сууцны төслийн хүрээнд Цагаанчулуут багт 11.9 га талбайд дахин төлөвлөн барилгажих хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төслийг хийж дуусгасан, Эрдэнэ багт 2.5 га талбайд Эрчим хүчний хэмнэлтэй амины орон сууцны төслийн ажлын явц 40 хувьтай явагдаж байгаа бол Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багт Уурхайчин- 1 хорооллын баруун талд амины болон цөөн давхар барилгын хэсэгчилсэн төлөвлөлтийг 10га талбайд хийлгэж зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна. Мөн Оюут багт Сархиа уулын энгэрт 4 га талбайд 300 айлын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр суурь судалгааны ажил хийгдэж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Орон сууцны хөтөлбөр”-ийг батлуулан Орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Баян-Өндөр сумын Уртын гол багт 260 айлын 5 блок орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлж тус барилгын төсөвт өртөг нь 27.4 тэрбум төгрөгөөс 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласнаар эхний ээлийн 4 блок барилга 100 хувийн гүйцэтгэлтэй ашиглалтад орсон ба 5-р блокийн ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна. Ашиглалтад орсон 4 блок барилгыг хүлээн авч, иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 28 иргэн түрээсээр, |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | 180 иргэн хөнгөлөлттэй үнээр худалдан авч нийт 208 айл тус орон сууцанд ороод байна. |
| 169. | | 8.1.2. Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилгын төсөл хэрэгжүүлнэ | 8.1.2.1. Гэр хорооллын алслагдсан багуудад байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй барилга бүхий эко хорооллыг бий болгох | байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй барилга бүхий эко хорооллын өрх | Тоо | 2023 | - | 50 | - | Хувийн хэвшил | - | - | 0 | Гэр хорооллын алслагдсан баг болох Баян-Өндөр сумын Эрдэнэ багт 2.5 га талбайд Хабрид хаус ХХК-тай хамтран Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төслийг хэрэгжүүлж, ажлын явц 40 хувьтай явагдаж байна. |
| 170. | | | 8.1.2.2. Ногоон зээлийн бодлогыг иргэд, олон нийтэд сурталчлах | Тухайн жилд олгосон ногоон зээлийн хэмжээ | Тэрбум.төг | 2023 | 5.98 | 7.0 | - | Банк санхүүгийн байгууллага | 3.4 | - | 48.5 | 2025 оны 05 дугаар сарын 6-ны өдөр Орхон аймагт "Хойд бүс Эрдэнэт-2025" эдийн засгийн форум, "Ногоон технологи" гадна талбайн үзэсгэлэнг А.Амарын талбайд зохион байгууллаа. Үзэсгэлэнд байгальд ээлтэй, ногоон технологийг дэмжих чиглэлээр "Ногоон" бүтээгдэхүүнийг худалдан авахад зориулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгож буй ногоон зээлийн үйлчилгээг үзүүлдэг 4 банк, 1 ББСБ-ыг оролцуулж, мэдээлэл өгч ажиллалаа. 2025 онд ХААН банк 15 иргэн, аж ахуйн нэгжид 2.6 тэрбум, Төрийн банк 3 иргэн, аж ахуйн нэгжид 700 сая, ХХБ 2 иргэнд цахилгаан автомашины 51.0 сая төгрөгийн ногоон зээлийг олгосон байна. |
| 171. | 8.2. Инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар хийж, гэр хорооллын айл өрхийг дэд бүтцэд холбогдох боломжийг бүрдүүлнэ. | 8.2.1. Хотын инженерийн шугам сүлжээний дэд бүтцэд гамшгийн эрсдэлийн үнэлгээг үе шаттайгаар хийж, гэмтэл, доголдлыг бууруулах, инженерийн дэд бүтцийг сайжруулах | 8.2.1.1. Гэр хорооллын багийн төвүүд болон айл өрхийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд ыг холбох боломжтой ИШС | Км | 2023 | Дулаан-27,6км, халуун ус-11км, цэвэр ус-43.6км, бохир-21.9км | ИШС 10%-иар нэмэгдсэн байна | 3000.0 | ОНТ | 8.8 хувиар нэмэгдсэн. | 2,500.0 | 88 | Дэнж багийн хэрэглэгчдийг төвлөрсөн шугамд холбож, өргөлтийн насос станц шинээр барих ажлын хүрээнд 2.5 тэрбум төгрөгийн 3424м цэвэр усны шугам шинэчлэх ажил хийгдэж Дэнж багийн хэрэглэгчдийг төвлөрсөн цэвэр усны шугамаас холбогдох, найдвартай эх үүсвэрт холбох ажил хийгдлээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2025 оны хооронд 2.9 тэрбум төгрөгөөр гэр хорооллын 7 багт дулаан цэвэр усны шугам барих ажил хийгдсэн. Нийт 5.78 км буюу Дулааны шугам 4.35 км , Хэрэглээний халуун ус болон цэвэр усны шугам 0,8 км, |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | | бохирын шугам 0.63 км , бохирын 56ш худаг гэх мэт төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. Тус төслийн хүрээнд гэр хорооллын 1245 айл төвлөрсөн ИШС-нд холбогдох боломж бүрдсэн ба одоогийн байдлаар 308 өрх ИШС-нд холбогдсон байна. |
| 172. | | | 8.2.1.2. Орон сууцны хорооллуудын ИШС-г үе шаттайгаар шинэчлэх | Шинэчлэх шаардлагатай шугам сүлжээний тоон мэдээлэл | Км | 2023 | Дулаан-80.7км, цэвэр ус-103.8км, бохир-83.5км | 12.5 км /дулаан 3.3 км, цэвэр 4км, бохир 5км/ ИШС-г шинэчлэнэ | 8000.0 | УТ ОНТ | 44.79 км / дулаан-25.6км, цэвэр - 18.6км бохир 0.59км/ | 30,200.0 | 100 | Орхон аймаг Эрдэнэт хотын инженерийн шугам сүлжээ нь: Цэвэр усны 119.5 км шугам сүлжээний 75.08 км буюу 64 хувь эдэлгээний хугацаа дууссан, Ариутгах татуургын 89.7 км шугам сүлжээний 55.6 км буюу 62 хувь эдэлгээний хугацаа дууссан, Дулаан хангамжийн 80.7 км шугам сүлжээний 33.08 км буюу 40.9 хувь эдэлгээний хугацаа тус тус дууссан байна. Үүнээс эхний ээлжид хийх шаардлагатай ажлыг эрэмбэлж гаргасан. Үүний хүрээнд 2025 оны төсөвт Шугам сүлжээний нэвтрэх чадварыг сайжруулж өргөтгөн шинэчлэх 23 ажилд 27.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөн, хэрэгжүүлсэн. Үүнд Нийт дулааны шугам- 25.6км, бохир усны шугам 0.59км, цэвэр усны шугам-18.6км, цахилгааны шугам-160км холбооны 1.0км шугам шинэчилсэн. Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр 8 инженерийн шугам сүлжээний ажил хийгдэхээр төлөвлөснөөс 3 ажил орон сууцны хороололд "Престиж инженеринг" ХХК гүйцэтгэж байна. |
| 173. | | | 8.2.1.3. “ЭДЦС” ТӨХК-ийг техникийн усаар тасралтгүй хангах шугам шинээр татах | Шугам татсан урт | Км | 2023 | - | 5.2 км | 5400.0 | УТ | 3.1 | 5,323.0 | 59.6 | “ЭДЦС” ТӨХК-ийг техникийн усаар тасралтгүй хангах шугам шинээр татах ажлын гүйцэтгэгчээр Ахин Ундрах" ХХК шалгарсан. Ф300мм голчтой 5.2км шугам татахаас 3.1 км шугам татах ажил хийгдсэн. Мөн ил шугам 300м татахаар зурагт тусгагдсан ба шугамын 40ш тулгуурыг суурилуулж 300м ил шугам татах ажил хийгдсэн |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Төлөвлөгөөний дагуу ажил үргэлжлэн хийгдэж байна |
| 174. | | | 8.2.1.4. Жаргалант сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх | Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | - | 100 | 2500.0 | ОНТ | - | - | 0 | Орхон аймгийн Жаргалант сумын засаг даргын Тамгын газар сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэхээр 2025 оны төсөвт 3.5 тэрбум төгрөг төлөвлөн тендер шалгаруулалт зарласан боловч амжилтгүй болсон. |
| 175. | 8.3. Эрчим хүчний найдвартай байдлыг хангана | 8.3.1. Дулааны цахилгаан станцыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, эрчим хүчээр бүрэн хангана. | 8.3.1.1. Орон сууц болон гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг шинээр хийх | Хотын гэрэлтүүлэг | Ш | 2023 | 10722ш | 11500ш | 1200.0 | ОНТ | 14872 | 5,039.0 | 100 | 2025 онд аймгийн хэмжээнд авто зам дагуух, явган зам дагуух мөн шаардлагатай байршил цамхагт гэрэл шинээр хийхээр 5 ажил төлөвлөсөн ба гүйцэтгэгчээр "Анд энерги" ХХК, "Мөнх номгон" ХХК шалгарч гүйцэтгэгчээр ажилласан. Үүнээс "Анд энерги" ХХК, 5 байршилд 539 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 10ш цамхагт гэрэл, авто зам , явган зам дагуух 78ш гэрэлтүүлэг, "Мөнх номгон" ХХК 9 байршилд 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 345ш гэрэлтүүлгийг суурилуулж хотын гэрэлтүүлэг 14872-т хүрсэн. |
| **176.** | | | 8.3.1.2. Гэр хорооллын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор 35кв-ын ЦДАШ-ын кольцоо схем үүсгэх, 35/6кВ-ын дэд станц барих ажлыг эхлүүлэх | Ажлын гүйцэтгэл | Хувь | 2024 | 10 | 50 | 21800.0 | УТ | 65 | 13149.0 | 100 | 1. Аймгийн хэмжээнд цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх, сайжруулах зорилгоор 35кв-ын тойрог схем үүсгэх 3 нэр төрлийн ажилд 13.1 тэрбум төгрөг төлөвлөн ажилласан. Уг ажлын хүрээнд Чингэл дэд станцаас 35/10 кВ-ын Даваат дэд станц хүртэлх 35 кВ-ын 13.059 км ЦДАШ барих ажилд "Виртуалсофт" ХХК, 35/10 кВ-ын 2х16 МВА Даваат дэд станц барих ажилд "Меса инженеринг" ХХК, Даваат дэд станцаас 35/10 кВ-ын Булаг дэд станц хүртэлх 35 кВ-ын 5.04 км ЦДАШ барих ажилд "Цацраг цог" ХХК-н гүйцэтгэгчээр шалгарч гүйцэтгэсэн. Ингэснээр 35кв-ын тойрог схемд оруулах нийт ажлын 65 хувийг энэ онд хийж гүйцэтгээд байна. Тус ажлын үр дүнд ачаалал |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | өндөр дэд станцуудын 1988 хэрэглэгчдийг шилжүүлэн холбож хэт ачааллаас шалтгаалан хязгаарлагдах, Бугат сумын дэд станцад гарсан гэмтлээс шалтгаалан тасралт гарах, эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээнээс шалтгаалсан хүчдэлийн уналт үүсэх зэрэг асуудлууд шийдвэрлэгдэх нөхцөл бүрдсэн. |
| **177.** | | | 8.3.1.3. Гэр хорооллын захын хэсгүүдийн айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, дэд станцууд барих | Шинээр баригдсан дэд станц | Тоо | 2023 | - | 4 | 600.0 | ОНТ | 22 | 1,800.0 | 100 | Баян-Өндөр сумын гэр хорооллын захын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулж, хүчдэлийн уналтыг бууруулах зорилгоор Баян-Өндөр сумын 11 багийн 22 байршилд 10 кВ-ын ЦДАШ, 10/0.4 кВ-ын 250 кВА чадалтай (КТПН) дэд станц барихаар нийт 22 ажил төлөвлөж тус ажлууд 100% дуусаж ашиглалтад оруулсан. Дээрх ажил хийгдсэнээр Эрдэнэ, Дэнж, Яргуйт, Их залуу, Уртын гол, Цагаанчулуут, Рашаант, Даваат, Наран, Баянбулаг, Баянцагаан, Чингэл, Баян-Овоот, Шанд, багуудын хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж 3172 хэрэглэгч хүчдэлийн уналтгүй болж хэвийн хүчдэлээр хангагдах нөхцөл бүрдсэн. Дэд станцуудын ачааллыг шилжүүлэх, 0.4кВ шугамд хэрэглэгчдийг холбох ажлын үр дүнд 2520 хэрэглэгчийн хүчдэл хэвийн түвшинд хүрсэн ба цаашид ачаалал шилжүүлж схемийн өөрчлөлт хийхтэй холбоотой хүчдэлийн уналттай үлдсэн хэрэглэгчдийн тоо буурна. |
| 178. | 8.4. Зам, замын байгууламжийн ашиглалтыг сайжруулна | 8.4.1. Авто замын сүлжээнд хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлнэ | 8.4.1.1. Хотын доторх хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хийх | Авто замын урт | Км | 2023 | 123.1 км | 125 км | 16000.0 | ОНТ | 135.3 | 26,700.0 | 100 | 2024-2025 онд авто зам, замын байгууламжийн 57 гэрээний 43 байршилд авто засвар шинэчлэлтийн ажил хийгдэж байна. Үүнээс: 2025 онд шинээр эхэлсэн 23 ажил, он дамжин хийгдэж буй 34 гэрээт ажил үргэлжлэн хийгдэж байгаагаас 12.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5.3 км авто |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | замыг шинээр, 27.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18.6 км авто замд их засвар шинэчлэлтийн ажил хийгдэж ашиглалтад оруулсан байна. Дээрх ажлууд хийгдсэнээр аймгийн хэмжээнд 135.3 км хатуу хучилттай авто зам ашиглагдаж байна. 2026 онд 8 байршилд авто замын ажил үргэлжлэн хийгдэнэ. Мөн Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 23, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар 2 байршилд авто зам, замын байгууламжийн ажил хийгдэж 100 хувь ашиглалтад оруулсан байна |
| 179. | | | 8.4.1.2. Асфальтан хучилттай авто замын шинэчлэлт, нөхөөс, тэмдэг тэмдэглэгээг үе шаттайгаар хийх | Хийгдсэн нөхөөс, тэмдэг, тэмдэглэгээний хэмжээ | М.кв, ш | 2023 | 5000 м.кв 60ш | 4000 м.кв 50ш | 300.0 | ОНТ | 7056 м.кв 74ш | 895.0 | 100 | Хотын хэмжээний асфальтан хучилттай автозамын засвар, арчлалтын ажлыг Хот тохижуулах газар хариуцан гүйцэтгэж байна. 2025 онд тус байгууллага нь хотын хэмжээний асфальтан хучилттай автозамд 3025 тн халуун асфальтаар, 23.6 тн хүйтэн асфальтаар тус тус 7056 м2 талбайг нөхөх ажлыг гүйцэтгэсэн байна. Мөн 26 ширхэг босоо тэмдэг тэмдгэлгээг шинээр суурьлуулж, 48 ширхэгийг засварласан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 14 байршилд 24 ширхэг хурд сааруулагч, хотын төвд 5869,53 м2, гэр хороололд 3778,3 м2 автозамын хэвтээ тэмдэг, тэмдэглэгээ 895.0 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээж аваад байна. |
| 180. | | | 8.4.1.3. Хотын доторх авто зогсоолыг нэмэгдүүлэх | Зогсоолын талбайн хэмжээ | М2 | 2023 | 2100 м2 | 2600 м2 | 600.0 | ОНТ | 7060 м2 | 2,700.0 | 100 | 2024-2025 онд Говилын 2-р сургуулийн зогсоол, Говилын 2-р цэцэрлэгийн зогсоол, Дэнж багийн Сэтгэц мэдрэлийн эмнэлгийн зогсоол, Эрдэнэ багийн 20-р сургуулийн зогсоол, Даваат багийн 17-р сургуулийн зогсоол, Уурхайчин багт Уран эгшиг сургуулийн авто |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | зогсоол, Баянбулаг багийн 18-р цэцэрлэгийн зогсоол, Хүрэнбулаг багт 4-23-р байрны авто зогсоол, Уурхайчин багийн үйлчилгээний төвийн баруун зүүн талын авто зогсоол, Орон сууцны Баян-Өндөр , ББ парк хотхон орчмын хатуу хучилттай авто замын ажлын нэг хэсэг болох 181 авто машины зогсоол зэрэг нийт 7060 м2 авто зогсоолыг шинээр барьж ашиглалтад оруулсан. |
| 181. | | 8.4.2. Гэр хорооллын шороон замыг сайжруулна | 8.4.2.1. Гэр хорооллын гудамж хоорондын хайрга хучилттай авто замыг шинэчлэн, сайжруулах | Сайжруулсан шороон замын урт | Км | 2023 | 9 | 10 км | 350.0 | ОНТ | 54.6 | 960.5 | 100 | Гэр хорооллын гудамж хоорондын хайрга хучилттай авто замыг сэргээн засварлах ажлыг Хот тохижуулах газар гүйцэтгэж 2025 онд 54.6 км сайжруулсан шороон замыг сэргээн засварласан. Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5 байршилд 5.06 км 2 мөртэй автозамыг 960.5 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэсэн. |
| 182. | 8.5. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ | 8.5.1. Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулна | 8.5.1.1. Хотын доторх нийтийн зорчигч тээвэр, үйлчилгээнд шаардагдах зогсоол, сүүдрэвч барих | Автобусны зогсоол нэмэгдсэн байдал | Тоо | 2023 | 104 | 108 | 400.0 | ОНТ | 109 | 20.0 | 100 | 2024-2025 онд авто зам, замын байгууламжийн 43 ажил үргэлжлэн хийгдэж байна. Тус авто замын ажлуудын хүрээнд 80 гаруй авто зогсоол хийгдэхээр төлөвлөсөн. 2025 онд Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтын 20.0 сая төгрөгөөр Рашаант багт нийтийн тээврийн автобусны 1 авто буудал барьж ашиглалтад оруулсан. Мөн Баянцагаан багийн ПДҮ-гийн хэсэгт 4 буудал 200.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. |
| **183.** | | | 8.5.1.2. Шинээр нийтийн тээврийн маршрут чиглэлийг бий болгох | Нэмэгдсэн маршрут, чиглэл | Тоо | 2023 | 7 | 8 | - | - | 9 | - | 100 | 2025 онд шинэ суурьшлын бүс болон авто замын шинэчлэлтэй уялдуулан иргэдийн санал хүсэлтийн хүрээнд 3 байршилд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл маршрутад өөрчлөлт оруулан иргэдийн ая тухтай зорчих нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Үүнд: Аймгийн Засаг даргын А/959 дугаар захирамжаар Ч9 буюу Яргуйт-Хангай бүс худалдааны төв-2А хороолол-Авто вокзал-Хүлэг зах чиглэлийг шинээр байгуулан Хот |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | тохижуулах газар хариуцуулан үйл ажиллагааг жигдрүүлээд байна. Шинэ чиглэл байгуулсантай холбоотой иргэдийн санал хүсэлтийн хүрээнд аймгийн Засаг даргын А/958 дугаар захирамжаар Шанд чиглэлийн маршрутыг 15-р сургууль- Халуун ус буюу дунд замаар явахаар шинэчлэн байгуулсан. Мөн “ББ-Од” ХХК-ийн Ч-3 буюу “Дэнж-Баян тал” чиглэлийн маршрутыг сунгаж Ёс заншлын өргөө хүртэл явахаар шинэчилсэн. |
| **184.** | | | 8.5.1.3. Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, зохицуулж, хяналт тавих, тээвэр зохицуулалтыг сайжруулах | Нөхөн олговрын хэмжээ | Тэрбум.төгрөг | 2023 | 1.6 | 2.1 | - | - | 2.2 | 2,200.0 | 100 | Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговорт 2.2 тэрбум төгрөгийг төлөвлөж санхүүжилтийг ББ-ОД ХХК, Тод од транс ХХК, Авто мастер төв ХХК, Хот тохижуулах газар зэрэг байгууллагуудад олгоод байна. |
| | | | | Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдэд олгож байгаа нөхөн олговрын журмын шинэчлэлт | Журмын шинэчлэлт | 2024 | 2018 онд шинэчилсэн | 2025 онд шинэчилнэ | - | - | - | - | 50 | Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдэд олгож байгаа нөхөн олговрын журмын төслийг боловсруулсан ба процессийн ажиллагаа хийгдэж байна. |
| 185. | 8.6. Явган болон дугуйгаар саадгүй зорчих боломжийг бүрдүүлнэ. | 8.6.1. Явган болон дугуйн замын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 8.6.1.1. Явган болон дугуйн замыг нэмэгдүүлэх | Тухайн жилд хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | 100 | 100 | 700.0 | ОНТ | 100 | 1,200.0 | 100 | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 35 Байршилд 52646 М2 явган замын шинэчлэх ажил хийгдсэн. Мөн 13 байршилд 13.9 км дугуйн замыг хийсэн. |
| 186. | | | 8.6.1.2. Явган хүний замын засвар шинэчлэлтийг хийж, ашиглалтыг сайжруулах | Засвар хийсэн явган хүний замын талбайн хэмжээ | М2 | 2023 | 2500 | 2800 | 300.0 | ОНТ | 42,900 | 200.0 | 100 | 2025 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 46 төрлийн засварын ажил хийгдсэн ба нийт 42,900 м2 явган замын засвар шинэчлэлт хийж, Хот тохижуулах газраас нийт 71 м2 явган зам талбай засварлаж, 56 гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих нөхцөл боломжоор хангаж ажилласан. |

| Хэрэгжилт 87.8% |
| --- |

_00_